

МОНГОЛ УЛСЫН ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Н.Дорждарь, Н.Золжаргал

2024 оны 7 дугаар сар

Natural Resource Governance Institute

Агуулга

1. Удиртгал 4
Ерөнхий тойм 4
Зорилго 6
2. Судалгааны арга барил 7
Аргачлал 7
Хамрах хүрээ 8
3. Судалгааны үр дүн 9
Гарч буй өөрчлөлтүүд 9
ОУИТБС-ын шаардлага ба гэрээний ил тод байдал 12
Шаардлага 2. Эрх зүйн болон институцын орчин, гэрээ, тусгай зөвшөөрөл 12
Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт 28
Шаардлага 6. Нийгэм, эдийн засгийн зардал 30
4. Дүгнэлт ба зөвлөмж 31
5. Хавсралт 36
Хавсралт А. Гэрээний төрөл 36
Хавсралт Б. Олборлох гэрээний жагсаалт 37
Эх сурвалж 39

Монгол Улсын гэрээний ил тод байдлын тойм судалгаа





Судалгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газрын дэмжлэг, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэв.

1. Удиртгал

Ерөнхий тойм

Энэхүү тайланд Монгол Улс дахь гэрээний ил тод байдлын талаар Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-ийн гүйцэтгэсэн тойм судалгааны дүнг танилцуулав. Судалгааг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС)-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны дэмжлэг, санхүүжилтээр гүйцэтгэсэн болно.

Монгол Улсын уул уурхайн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүн, экспорт, төсвийн орлого, гадаадын хөрөнгө оруулалтад томоохон хувь нэмэр оруулдаг, эдийн засагт чухал үүрэгтэй. Өндөр цалинтай ажлын байр бий болгож, орон нутгийн, ялангуяа уул уурхайн бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд хөшүүрэг болж ирсэн. Нүүрс, зэс, алт болон бусад ашигт малтмал улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд ихээхэн үүрэгтэй бөгөөд 2023 онд 13.9 тэрбум ам.долларын экспортын орлогыг бүрдүүлсэн нь нийт экспортын 92 хувь, төсвийн орлогын 29.9 хувьтай тэнцэж байна.[1] Монгол Улс газрын тосыг харьцангуй бага хэмжээгээр олборлодог ч төсвийн орлогынхоо тодорхой хувийг тус бүтээгдэхүүнээс бүрдүүлж, орон нутгийн иргэдэд өгөөж нь очиж байдаг. Уг салбар 2023 онд 4.7 сая баррель түүхий газрын тос олборлож, 364.7 сая ам.долларын экспортын орлого олсон нь төсвийн орлогын 1.3 хувьтай тэнцэж байна.[2]

Уул уурхайн салбар энэ жишээгээр эдийн засагт чухал ач холбогдолтой ч тулгарч буй олон бэрхшээл цаашдын хөгжлийг нь тушиж байна. Уул уурхайтай холбоотой авлигын асуудлууд хор уршиг ихтэй байж, байгаль орчин, нийгэмд тулгамдаж буй сорилтууд хүндрэл учруулсаар байна. Монгол Улс нь тус салбарын үр өгөөжөөс зохих түвшинд хүртэж чадахгүй байна гэх төсөөлөл түгээмэл. Ялангуяа судалгаа, дүн шинжилгээнд гэхээс илүү популист хандлагад үндэслэн уул уурхайн салбарын бодлого үе үе өөрчлөгддөг байдал хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж байна. Хөрөнгө оруулагчид болон Засгийн газрын хооронд маргаан

[1] Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам . “Эрдэс баялгийн салбарын статистик 2023”. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2023. www.mmhi.gov.mn/%d1%81%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0% bd-%d1%81%d1%82%d0%b0%d1%82%d0%b8%d1%81%d1%82%d0%b8%d0%ba/ .

[2] Өмнөхтэй ижил

өрнөж, нэмж орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, шинээр илрэх орд болон хөгжүүлэх төсөл цөөрсөн нь эл байдлыг илтгэж байна.

Монгол Улс тус салбарын эдийн засагт оруулах онцгой үүрэг болон салбарын сайн засаглалын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, салбарын ил тод, хариуцлагатай менежментийг дэмжих зорилгоор 2006 онд ОҮИТБС-д[3] нэгдсэн. ОҮИТБС нь салбарын ил тод байдал, сайн засаглалын дэлхий нийтийн стандартыг тогтоож, орлого, төлбөр, олборлолтын хэмжээ, түүхий эдийн борлуулалт, уул уурхайн компаниудын өмчлөл, хөрөнгө оруулагчид болон засгийн газрын хоорондын харилцааг зохицуулдаг олборлолтын гэрээ зэрэг чухал мэдээллийг ил тод болгохыг компаниуд болон засгийн газраас шаарддаг. Тухайлбал, ОҮИТБС-ын Стандарт нь олборлох гэрээг ил тод байлгах, олборлох төслөөс тус улс хүртэж буй үр нөлөөг нягтлах боломжийг иргэдэд өгөх зорилгоор 2021 оны нэгдүгээр сараас эхлэн бүх гэрээ, тусгай зөвшөөрлийг олон нийтэд зориулж нийтлэх шаардлагыг тавих болсон.[4]

Гэрээг ил тод нийтлэх нь олборлох салбарын сайн засаглал, ил тод байдалд онцгой нөлөөтэй бөгөөд салбарын бүх оролцогч талд ашиг тустай. Тухайлбал, төр засгийн хувьд зохицуулалтын тогтолцоогоо бэхжүүлж, салбарт оновчтой хяналтыг хэрэгжүүлэхэд тустай бол компаниудад нэр хүндтэй холбоотой үүсэх эрсдэлээ бууруулж, бусад оролцогч талуудын итгэлцлийг нэмэгдүүлэхэд дэм болдог. Харин иргэдийн хувьд засгийн газар, компаниудаас хариуцлага нэхэх, тухайн улсад орох эдийн засгийн үр өгөөж болон бусад үр нөлөөг хянах боломжийг олгодог.[5]

Монгол Улс дахь гэрээний ил тод байдал нь ОҮИТБС-ын хүрээнд болон бусад сувгаар хэрэгжүүлж буй ажлын дүнд ихээхэн хувьсаж байна. ОҮИТБС-ын баталгаажуулалтын хамгийн сүүлчийн тайланд[6] тусгайлсан мэдээллийн портал дээр нэлээд тооны гэрээг нийтэлснээр ОҮИТБС-ын холбогдох шаардлагыг ерөнхийдөө хангаж байгаа ч гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад засгийн газрын бодлого, түүний хэрэгжилтийг сайжруулах шаардлага байсаар байгааг тэмдэглэжээ.

---

[3] ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС” www.eitimongolia.mn.
[4] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. “ОҮИТБС-ын шаардлага 2.4,” www.eiti.org/sites/default/files/2022-01/EN%20EITI%20GN_2.4.pdf
[5] Өмнөхтэй ижил
[6] ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. “Монголын ОҮИТБС-ын 2022 оны Баталгаажуулалтын тайлан,” 2022 оны 10 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-10/EITI%20Validation%20of%20Mongolia%20%282022%29%20-%20Finalation%20Val %20%287-pcap%202022%29%20%28EN%29.pdf

Уул уурхайн салбарт ашигладаг зарим гэрээг ил тод нийтлэх шаардлагыг тусгах замаар Монгол Улсын холбогдох хууль тогтоомж ч хувьсан өөрчлөгдөж байна. Нээлттэй засгийн түншлэл[7] зэрэг бусад санал санаачилгууд олборлох салбарын гэрээний ил тод байдлыг мөн чухалчилж ирсэн. Зарим компаниуд, үүнд ялангуяа хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд сайн дурын үндсэн дээр, хуульд заасан шаардлагын дагуу, эсхүл авлигын эрсдэлийг бууруулах, олон нийтийн төсөөлөл, ойлголттой холбоотойгоор төрийн байгууллагатай байгуулсан гэрээгээ ил тод нийтэлсэн байдаг.

Засгийн газар болон компаниуд олон гэрээг ил нийтэлсэн ч холбогдох бүх гэрээг хамарсан эсэх нь тодорхой бус, гэрээг ил тод болгох зохицуулалт, тогтолцоо хангалтгүй хэвээр байгаа тухай энэ судалгааны дараагийн хэсэгт өгүүлсэн болно.

Зорилго

Энэхүү судалгааны хүрээнд Монгол Улс дахь олборлох салбарын гэрээг ил тайлагнах ОҮИТБС-ын шаардлага, хууль эрх зүйн орчин болон өнөөгийн практик туршлагыг нягтлан үзэв. Гэрээний ил тод байдал нь салбарын засаглалыг бэхжүүлэхэд онцгой үүрэгтэй бөгөөд ОҮИТБС-ын Стандартын дагуу хүлээсэн үүргийг бүрэн хангах нь үндсэн зорилго юм. Судалгааны гол зорилт нь ОҮИТБС-ын Стандарт болон газрын тос, уул уурхайн салбарын гэрээний ил тод байдлын талаар баримталж буй бодлого болон түүний хэрэгжилт зэргийн хоорондын зөрүүтэй байдлыг тогтоох, гэрээг ил тайлагнахад тулгарч буй саад бэрхшээлд дүн шинжилгээ хийх, тайлагналыг сайжруулах талаар зөвлөмж өгөх явдал юм. Энэ хүрээнд өнөөг хүртэл байгуулсан холбогдох бүх гэрээг тодорхойлж баримтжуулах, нийтлэх ёстой гэрээний иж бүрэн жагсаалтыг гаргах, гэрээний ил тод байдлыг хангах хууль эрх зүйн шаардлага, өнөөгийн практикт дүн шинжилгээ хийх юм. Судалгааны хүрээнд гэрээг өргөн хүрээнд буюу ОҮИТБС-ын Стандартад нийцэхүйц байдлаар тодорхойлж, үндсэн гэрээний бүрэн эхээс гадна тухайн гэрээгээр зохицуулж буй харилцааг ойлгоход чухал дагалдах аливаа хавсралт, нэмэлт, өөрчлөлтийг хамтатган ойлгож байгаа. Харин гэрээний тусгайлсан нөхцөлөөр бус Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтлэг байдлаар зохицуулагддаг тусгай болон ердийн зөвшөөрлийг судлаагүй болно. Эдгээр зорилтыг дэвшүүлснээр ОҮИТБС-аар

[7] Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2024 оны 1 дүгээр сарын 8. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december/ .

дамжуулан Монгол Улсад эрдэс баялгийн хариуцлагатай засаглалыг дэмжих, салбарын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийг зорьсон болно.

2. Судалгааны арга барил

Аргачлал

Судалгааны хүрээнд дараах асуултад хариулахыг зорьж байна. Үүнд:

- Олборлох салбарт ямар төрлийн гэрээг ашигладаг вэ?
- Монгол Улсад гэрээг ил тод болгох ямар үүрэг амлалт авсан болон хуулийн ямар шаардлага тавигддаг вэ?
- Гэрээг ил тод болгох өнөөгийн практик туршлага нь авсан үүрэг амлалт, холбогдох хуулийн шаардлагуудаас хэр зөрүүтэй байгаа вэ?
- Гэрээг ил болгоход ямар саад бэрхшээл тулгарч байна? Тэдгээрийг хэрхэн даван туулах вэ? зэрэг асуултууд хамаарна.

Эдгээр асуултад хариулах зорилгоор олон арга хэрэгслийг ашиглах аргачлалыг уг судалгаанд баримталсан. Тухайлбал:

- **Баримт материалыг судлах:** ОҮИТБС-ын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох эх сурвалж, ОҮИТБС-ын Стандартын заавар, шаардлага, хууль эрх зүйн баримт бичиг, энэ чиглэлийн судалгаа зэргийг тоймлон судалж, Монгол дахь олборлох салбарын гэрээг ил болгох дүрэм журам, практик туршлагын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв.
- **Оролцогч талуудтай зөвлөлдөх:** Гэрээг ил тод болгох практик, тулгарч буй саад бэрхшээл болон нөөц боломжийг тал бүрээс нь тодорхойлох зорилгоор төрийн албан хаагчид, салбарын болон иргэний нийгмийн төлөөлөлтэй уулзаж, ярилцав. Монгол Улсын ОҮИТБС-ын Ажлын албатай харилцаж, ОҮИТБС-ын Стандарт, шилдэг туршлага, тулгамдаж буй бэрхшээлийг тодруулсан.
- **Гэрээний дүн шинжилгээ:** Холбогдох вэбсайт, бусад эх сурвалжаас авах боломжтой гэрээг нягтлан үзэж, эдгээр гэрээнд ил тод байдлыг хангах шаардлага байгаа эсэхийг үнэлэх, хууль эрх зүйн болон гэрээний холбогдох шаардлагуудаас бодит байдал зөрж буй эсэхийг тодорхойлоход анхаарав.

Эдгээр аргачлалыг хослуулах замаар гүйцэтгэсэн энэ судалгаа нь Монгол дахь олборлох салбарын гэрээний ил тод байдлыг цогц байдлаар үнэлэхийг зорьсон болно.

Хамрах хүрээ

Олборлох гэрээ нь хамрах хүрээ, мөнгөн дүн, эрх зүйн хэлбэр, хүчинтэй хугацаа, холбогдох төслийн хувьд гүйцэтгэх үүрэг, оролцогч талууд, төвөгшил зэрэг хүчин зүйлсээс хамаарч олон төрөлтэй байдаг. Олборлох үйл ажиллагаанд олон талууд оролцдог тул тэдгээрийн ярвигтай харилцааг зохицуулах зорилгоор олон төрлийн гэрээ үйлчилдэг. Энэ судалгаа нь төр засгийг төлөөлж болох Засгийн газар, орон нутгийн удирдлага, төрийн өмчит аж ахуйн нэгж болон хөрөнгө оруулагчийг төлөөлж болох хувийн, нийтийн болон төрийн оролцоотой компаниудын хооронд буюу төр-хөрөнгө оруулагчийн хооронд үүсэх гэрээний харилцаанд төвлөрсөн болно. Харин хувийн өмчлөлтэй аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан гэрээг хамрахгүй.

ОҮИТБС-ын Стандартад гэрээ, хэлэлцээрийг ил тод нийтлэх дүрмээс гадна тэдгээрийн тодорхойлолтыг агуулсан байдаг. Гэрээний талаарх гол шаардлагуудыг 2.4 "Гэрээ ба тусгай зөвшөөрөл"[8] хэсэгт тусгасан байдаг ч гэрээнд хамаарах бусад заалтуудыг 2.1 "Эрх зүйн хүрээ ба төсвийн дэглэм" болон 2.2 "Гэрээ ба тусгай зөвшөөрөл олголт" хэсгээс тус тус үзэж болно. Стандартад "гэрээ" гэдэг нь “газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын нөөцийг ашиглахтай холбогдуулан тодорхой нөхцөлүүдийг тусгасан, төр засгийн зүгээс олгосон эсхүл байгуулсан гэрээ, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээ, эсхүл бусад гэрээний бүрэн эхийг хэлнэ” гэж заажээ. Олон талт оролцогчдын бүлэг нь материаллаг байдал болон бодит боломжид тулгуурлан хайгуулын ямар гэрээг ил тод нийтлэхийг тодорхойлох ёстой.[9] Ашиглалтын болон хайгуулын гэрээний аль алийг ил тод нийтлэх шаардлага тавигдаж байгаа.

Монгол Улсад ашиглалт, хайгуулын үйл ажиллагаанд аль алинд нь тусгай зөвшөөрөл авахыг шаарддаг ба эдгээрийг ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл гэж нэрлэдэг. Харин олборлолтын болон хайгуулын бүх үйл ажиллагаа эсхүл бүх төсөл дээр үйл ажиллагааны үндсэн нөхцөлийг тодорхойлсон гэрээг байгуулахыг шаарддаггүй. Лиценз гэж заримдаа нэрлэгддэг тусгай зөвшөөрлийг дагалдуулан тусгайлсан гэрээ байгуулахыг шаарддаггүй бөгөөд харин эдгээр лицензтэй холбоотой нөхцөлүүдийг хууль тогтоомжид, ялангуяа Ашигт

[8] ОҮИТБС, “ОҮИТБС-ын стандарт 2023” (ОҮИТБС, 2023), www.eiti.org/sites/default/files/2024-04/2023%20EITI%20Standard_Parts1-2-3.pdf.
[9] ОҮИТБС-ын Стандарт, Хуудас 20.

малтмалын тухай хуульд[10] зааж өгсөн байдаг. Тусгай зөвшөөрөл олголт болон эзэмшилтэй холбоотой мэдээлэл нь ОҮИТБС-ын ил тод байдлын шаардлагад хамаардаг хэдий ч гэрээний ил тод байдалтай шууд холбогдохоос бусад тохиолдолд эдгээр үйл явцыг эл судалгааны хүрээнд авч үзээгүй болно.

3. Судалгааны үр дүн

Тайлангийн энэ хэсэгт сүүлийн арав гаруй жилийн хугацаанд гэрээний ил тод байдлыг сайжруулах талаар Монгол Улсад өрнөсөн санаачилгын тухай тусгасан бөгөөд уул уурхайн салбарын гэрээний ил тод байдал, гэрээг ил тод болгох явцаас хуримтлагдсан туршлагыг танилцуулж байна. Гарч буй үр дүнг гэрээнд хамаарах ОҮИТБС-ын шаардлагуудтай харьцуулан авч үзэж, эдгээр шаардлагыг ОҮИТБС-ын хүрээнд эсхүл бусад арга замаар хэрэгжүүлж ирсэн эсэх, дотоодын хууль тогтоомж болон практик туршлага нь хэрэгжилтийг дэмжих эсхүл удаашруулах нөхцөл болж буйг судалсан болно.

Гарч буй өөрчлөлтүүд

Монгол Улсын ОҮИТБС нь 2012 оноос хойш жил бүрийн ажлын төлөвлөгөөгөө хэвлэн нийтлэх болон чухал мэдээллийн нээлттэй байдалд анхаарч, олборлох салбарын гэрээний ил тод байдлыг хангах хүсэл зоригоо тууштай нотолж ирсэн.

Олон талт оролцогчдын бүлэг (ОТОБ)-ийн хүрээнд гэрээний ил тайлагналыг хангах тусгайлсан дэд ажлын хэсгийг 2014 онд байгуулсан нь[11] талуудын дэмжлэг оролцоог бий болгож, тус ажлын хувьд нэн чухал алхам болсон юм. Улмаар иргэний нийгмийн байгууллагууд гэрээний ил тод байдлын санал санаачилгыг түүчээлж ирсэн. Тухайлбал, Нээлттэй нийгэм форум (ННФ) нь Монгол Улсын Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг үүсгэх, санхүүжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. Энэ мэдээллийн санг 2019 оны 4 дүгээр сарын 22-нд албан ёсоор нээснээс[12] хойш газрын тос, уул уурхайн гэрээний мэдээллийг нэгтгэн төвлөрүүлсэн нэн чухал сан болж хөгжсөн. Цаашилбал, ББЗХ болон бусад оролцогч талууд чадавхыг бэхжүүлэх төрөл бүрийн хөтөлбөрийн хүрээнд талуудад шаардлагатай мэдлэг, ур

[10] “Ашигт малтмалын тухай хууль” 2006 оны 7 дугаар сарын 8.
[11] ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС 2014 оны ажлын төлөвлөгөө,” 2014. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/fe4x71hog1xhqv1n/EITIM_POA_2014en.pdf .
[12] Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам. “Олборлох гэрээ олон нийтэд нээлттэй.” Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, www.mmhi.gov.mn/2019/04/22/4456/ .

чадвар эзэмшүүлэхийн төлөө идэвхтэй ажиллаж байна. Эдгээр сургалт хөтөлбөр нь гэрээний ил тод байдлын талаарх ойлголтыг сайжруулах, гэрээний тайлагналыг нэмэгдүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг үзүүлсэн.

Гэрээний ил тод байдлыг сайжруулах ажил эдгээр цөөн хэдэн байгууллагаар хязгаарлагдахгүй. Иргэний нийгмийн олон байгууллага орон нутгийн засаг захиргааны түвшний гэрээ, хэлэлцээрийн тухай сургалтуудыг идэвхтэй зохион байгуулахад оролцож ирсэн. Тэдний хүчин чармайлт нь алслагдсан орон нутагт ч ил тод байдлын үр өгөөжийг хүргэж, нутгийн иргэд мэдлэгээ дээшлүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа өрнөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Засгийн газар уул уурхай, газрын тосны гэрээг ил тод болгох хүсэл зоригоо гэрээний мэдээллийн сангийн нээлтийн арга хэмжээний үеэр бататган мэдэгдсэн байдаг.[13] Гэсэн хэдий ч ОҮИТБС-ын тайланд эсхүл Гэрээний мэдээллийн санд бүх гэрээг нийтлэх талаарх тодорхой ажил, ахиц дэвшил хангалтгүй байгаа нь анхаарал татсаар байна. Гэрээний ил тод байдлыг бүрэн хэмжээнд хангахад Засгийн газрын тууштай манлайлал нэн чухал хэвээр байна.

Монгол Улсын 2022 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайланд[14] олон нийтэд ил болсон гэрээний 75 хувийг (928 гэрээний 693-ийг) орон нутгийн түвшний гэрээ буюу орон нутгийн төр захиргаа болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ эзэлж байна. Эдгээр гэрээний заримыг (жишээлбэл, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ) ил болгохыг хуульд тусгайлан зааж өгсөн байдаг бол ус, газар ашиглах, бичил уурхайн олборлолт гэх мэтэд ийм шаардлага тавигддаггүй байна.

Гэрээний мэдээллийн санг ННФ-ын санхүүжүүлж, ажиллуулдаг. Харин ОҮИТБС-ын Ажлын алба дэмжлэг үзүүлдэг байна. Ажлын алба нь ОҮИТБС-ын дэд зөвлөлд албан бичиг илгээж, орон нутгийн захиргаа болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээг мэдээллийн санд хэрэглэгчийн эрхээр нэвтрэн орж нийтлэхийг уриалж ажилладаг. Гэвч гэрээг хянах тогтолцоо, хүний нөөцийн асуудлаас шалтгаалж ОҮИТБС-ын нэгтгэл тайланд дурдсан болон

---

[13] Роберт Питман, “Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд,” 2019 оны 1 дүгээр сар, www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolias-missing-oil-gas-and-mining-contracts.pdf.
[14] ОҮИТБС-ын Ажлын алба. “Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан,” 2023. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/ccgk80kk82n69ur3/17-%D1%80%20%D1%82%D0%B%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf .

Гэрээний мэдээллийн санд байршуулсан гэрээнүүд хоорондоо зөрүүтэй байдаг нь олон нийтэд хэвлэн нийтэлсэн гэрээний иж бүрэн гэдэгт эргэлзээ төрүүлж байна.

Гэрээг ил болгох практик нь Монгол дахь уул уурхайн компаниудад харилцан адилгүй байдаг. Монгол Улсын хувьд хамгийн чухал гэж үзэж болох төслийг удирдаж буй "Оюу Толгой" ХХК зэрэг зарим компаниуд гэрээ, хэлэлцээрийг хуульд шаардаагүй байхад буюу сайн дурын үндсэн дээр компанийн вэб сайтад нийтэлдэг. Энэ нь ил тод байдлыг сайжруулах, мэдээлэл авах боломжийг олон нийтэд олгож байна. "Эрдэнэс Оюу Толгой" (34 хувийн хувьцаа эзэмших замаар Монголын Засгийн газрыг төлөөлдөг) болон Рио Тинто (66 хувийн хувьцаа эзэмшигч, төслийн менежер) компанийн хамтарсан "Оюу Толгой" ХХК нь гэрээний ил тод байдлыг хангах хүсэл эрмэлзлийн жишээ юм. Эдгээр талуудын хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ (2009 он) нь Засгийн газар болон хөрөнгө оруулагчийн хоорондын санхүү, үйл ажиллагааны харилцааны үндсэн нөхцөлийг тодорхойлж, хувь нийлүүлэгчдийн гэрээ (2011 он) зэрэг дагалдах гэрээнүүд, байгаль орчны баримт бичиг (нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон хамгаалалтын тайлан гэх мэт) нь компанийн вэбсайт дээр олон нийтэд нээлттэй байна.[15] Нөгөө талд нь Орано (66 хувийн хувьцаа эзэмшигч) болон Монголын төрийн өмчит Мон-Атом (34 хувь эзэмшигч) компани хамтарч 2015 онд байгуулсан "Бадрах Энержи" ХХК одоогийн байдлаар ил тод байдлыг энэ хэмжээнд хангахгүй байна. Тус компанийн вэб хуудаст хувь нийлүүлэгчдийн гэрээг[16] 2013 оны 10 дугаар сард, бусад нэмэлт гэрээ болох Орд ашиглах гэрээ (2016)-г Ашигт малтмал, газрын тосны газартай, хамтын ажиллагааны гэрээ (2018)-г Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг дарга, Сайншанд сумын Зүүнбаян багтай[17] байгуулсан гэж дурдсан боловч эдгээр гэрээ компанийн вэб сайт болон Гэрээний мэдээллийн санд нийтлэгдээгүй байна.

"Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд" хэмээх бодлогын хураангуйг ББЗХ-ээс 2019 онд нийтлэхдээ олон гэрээ ил тод бус байгааг онцолсон.[18] Энэхүү дүгнэлт нь доор тайлбарласны дагуу өнөөдөр ч хүчин төгөлдөр байна.

---

[15] Оюу толгой. "Оюу толгой", www.ot.mn/agreements/ .
[16] Монгол дахь Орано групп, www.orano.group/en/orano-across-the-world/mongolia
[17] Бадрах энержи. www.badrakhenergy.com/en/home-en/ .
[18] Роберт Питман "Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд".


ОУИТБС-ын шаардлага ба гэрээний ил тод байдал

Шаардлага 2. Эрх зүйн болон институцын орчин, гэрээ, тусгай зөвшөөрөл

2.1 Хэрэгжүүлэгч улс орнууд ...газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, олборлолтыг зохицуулдаг гэрээ, тусгай зөвшөөрлийн төрлийн тухай тайлбарыг нийтлэх шаардлагатай..."[19]

ОУИТБС-ын жилийн тайлангийн гэрээний ил тод байдлын тухай хэсэгт[20] ОУИТБС, ННФ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас[21] мэдээллийн санд нийтэлдэг гэрээний ил тод байдал, гэрээний төрлийн тухай тайлагнасан. Энэ тайлангийн хавсралтад 984 гэрээг жагсааж, 19 төрөлд ангилсан бөгөөд Зураг 1-т эдгээр гэрээний томоохон ангиллыг харуулав[22].

Зураг 1. 2022 оны ОУИТБС-ын нэгтгэлийн тайланд дурдсан гэрээний төрөл



Гэрээний мэдээллийн сан болон ОУИТБС-ын жилийн тайланд нийтэлсэн гэрээний дийлэнх нь орон нутгийн харилцаатай холбоотой нь тодорхой харагдаж байна. Эдгээр гэрээ орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, нийгмийн хариуцлагын гэрээ зэрэг өөр өөр нэртэй

[19] ОУИТБС, "ОУИТБС-ын стандарт 2023." Хуудас 17
[20] Монголын ОУИТБС-ын Ажлын алба, "Монголын ОУИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан", www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/ccgk80kk82n69ur3/17-%D1%80%820D%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf.
[21] "Гэрээний мэдээллийн сан," www.iltodgeree.mn.
[22] Монголын ОУИТБС-ын Ажлын алба, "Монгол Улсын ОУИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан, Хуудас 135-136, Хүснэгт 90".

байна. Ашигт малтмалын тухай хуульд[23] тусгасны дагуу байгуулдаг энэ төрлийн гэрээг Захиргааны ерөнхий хуульд хамаарах захиргааны шийдвэр гэж үзэж болох тул энэ хуульд заасан шаардлага, ил тод байдлыг мөрдөх ёстой. Хоёр дахь том бүлэг гэрээ нь бичил уурхайтай холбоотой бөгөөд бичил уурхайчид нэгдэж бүлэг, хоршоо байгуулах замаар орон нутгийн харьяа нутаг дэвсгэр дээр, урьдчилан тогтоосон талбайд үйл ажиллагаа явуулахаар орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулдаг.

Гэрээний мэдээллийн сан дээр олон төрлийн гэрээг нийтэлж, ОҮИТБС-ын тайланд эдгээр гэрээг ашиглаж, Монгол Улсын гэрээний ил тод байдлыг үнэлж, тайлагнадаг боловч компаниудад хайгуул хийх, ашиглах эрхийг олгодог үндсэн гэрээ аль нь болох, аль нь дагалдах гэрээ болох талаар тайлбар, дүн шинжилгээ хийдэггүй. Тухайлбал, томоохон орд ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд ашигт малтмалын тодорхой ордыг ашиглах нөхцөлийг тодорхойлдог бол газар эсхүл ус ашиглах гэрээ дангаараа чухал ач холбогдолтой боловч хөрөнгө оруулагчдын үндсэн үйл ажиллагааг дэмждэг гэдэг утгаараа дагалдах гэрээнд тооцож болохоор байна. Гэрээний мэдээллийн сан дээр нийтэлсэн бүх гэрээ ОҮИТБС-ын тайлангийн хавсралтад ороогүй гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

ОҮИТБС-ын тайланд гэрээний нарийвчилсан жагсаалтаас гадна хууль тогтоомжийн жагсаалт, гэрээг ил болгох, нийтлэхтэй холбоотой тодорхой заалтыг тайлагнадаг.[24] Гэсэн хэдий ч эдгээр хууль тогтоомжид тусгайлан ямар шаардлага тавьдаг талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, ОҮИТБС-ын ил тод байдлын шаардлагад хамаарах бүх гэрээг нийтэлсэн эсэхээс эхлээд гэрээний зорилго, хамрах хүрээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайланд тусгадаггүй. Монгол Улсад мөрдөгдөж буй гэрээний үндсэн төрөл, гэрээний зорилго болон эдгээр гэрээг дотоодын хууль тогтоомжийн дагуу заавал байгуулдаг эсэх талаар доор тайлбарлав.

Монгол Улсын олборлох салбарт дараах төрлийн гэрээг нийтлэг ашиглаж байна. Үүнд:

- **Хөрөнгө оруулалтын гэрээ:** Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эдгээр том хэмжээний гэрээ нь 500 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийх компани болон Засгийн газрын хоорондын харилцааг зохицуулдаг. Энэ төрлийн гэрээ эдийн засгийн бүх салбарт хамаарах боловч бодит байдал дээр олборлох салбарын хүрээнд хэд хэдэн гэрээнд гарын үсэг зурсан байна. Эдгээр гэрээний хүрээнд татварын хэмжээг

[23] Ашигт малтмалын тухай хууль, 42 дугаар зүйл.
[24] ОҮИТБС-ын Ажлын алба, “Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэлийн тайлан, Хуудас 134-135, Хүснэгт 89”.

тогтворжуулах, хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгаа олгох замаар үйл ажиллагааны орчныг тогтвортой байлгах боломж олгодог. Гэрээнд гарын үсэг зурсан талууд нь хөрөнгө оруулагч болон төрийг төлөөлж буй Засгийн газар байна. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг заавал шаарддаггүй буюу сонгож байгуулдаг бөгөөд хөрөнгө оруулагчид хүсэлт гаргаж болох ба гэрээний хугацаа 15-18 жил үргэлжилдэг. Олонд хамгийн танигдсан хөрөнгө оруулалтын гэрээ бол Рио Тинто болон Засгийн газар хоорондын Оюутолгой төслийг бүтээн байгуулах, үйл ажиллагааг явуулах гэрээ юм. Уг гэрээг 2009 онд буюу хөрөнгө оруулалтын тухай шинэ хууль батлагдаж, хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө Ашигт малтмалын тухай хуулийг мөрдлөг болгож байгуулсан. ОҮИТБС-ын 2022 оны тайланд Гэрээний мэдээллийн санд нийтэлсэн хөрөнгө оруулалтын дөрвөн гэрээг дурдсан боловч тэдгээрийн хоёр нь ашигт малтмалын салбарт бус цементийн үйлдвэрлэлтэй хамааралтай гэрээ болохыг судалгааны явцад олж мэдлээ.

- **Хувьцаа эзэмшигчдийн гэрээ:** Эдгээр нь хөрөнгө оруулагчдын хооронд байгуулдаг гэрээ бөгөөд бид судалгааны хүрээнд төрийг төлөөлж Засгийн газрын байгууллагууд болон хөрөнгө оруулагчид хооронд байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийв. Энэ төрлийн гэрээнд төрийг төлөөлж буй этгээд нь уул уурхайн төслийн тусгай зөвшөөрөл эзэмшигч эсхүл төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьцааг албан ёсоор эзэмшдэг төрийн өмчит компаниуд байна. Хувьцаа эзэмшигчид нь компанийн засаглал, төслөөс хүртэх Засгийн газрын санхүүгийн үр өгөөж, тал тус бүрийн үүрэг, хариуцлагын талаарх нөхцөлийг гэрээгээр тохиролцдог. Тиймээс Засгийн газар уул уурхайн компанид хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд уул уурхайн төслийн тухайн улсад үзүүлэх үр нөлөөг ойлгох нь тун чухал юм. Эдгээр гэрээг заавал байгуулахыг хуульд шаарддаггүй ч талуудын үр дүнтэй хамтын ажиллагааны баталгаа гэж үздэг. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулаагүй тохиолдолд ийм гэрээгээр зохицуулдаг харилцааг Компанийн тухай хууль зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу зохицуулна. Рио Тинто (Оюу Толгой ХХК-ийн 66 хувийг эзэмшдэг) болон төрийн өмчит “Эрдэнэс Оюу Толгой” (Засгийн газрын 34 хувийг эзэмшдэг) компаниудын хооронд байгуулсан Оюутолгой төслийн гэрээнд хувьцаа эзэмшигчдийн гэрээ эдгээр компаниудын вэб сайт болон бусад эх сурвалжид байдаг ч ОҮИТБС-ын тайланд энэ болон бусад хувь эзэмшигчдийн гэрээг тусгаагүй байна.
- **Орд ашиглах гэрээ:** Стратегийн ордыг ашиглах уул уурхайн төсөлд төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, түүнчлэн уул уурхайн компаниуд төсвийн хөрөнгөөр илрүүлсэн ордыг ашигласны нөхөн төлбөрийг Засгийн газарт төлөхөөр Ашигт малтмалын тухай

хуульд заасан байдаг. ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд[25] орд ашиглах 11 гэрээг бүртгэсэн боловч эдгээр нь үнэндээ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээ бөгөөд орд ашиглах гэрээ биш байв. Гэрээний мэдээллийн сан болон ОҮИТБС-ын жилийн тайлангийн хавсралтын аль алинд орд ашиглах гэрээ багтаагүй бөгөөд өнөөдрийн байдлаар ийм төрлийн гэрээ мөрдөгдөж буй эсэх, түүнчлэн хэчнээн гэрээ хүчин төгөлдөр үйлчилж буй нь тодорхойгүй байна.

- **Операторын үйлчилгээний гэрээ:** Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь төрийн өмчит компаниудын хэрэгжүүлж буй томоохон төсөлд уул уурхайн үйлчилгээ үзүүлэх оператор компаниудыг хөлсөлж авах үед энэ төрлийн гэрээг ихэвчлэн байгуулдаг. Тухайлбал, хамгийн том нүүрс олборлогч, төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани хувийн уул уурхайн үйлчилгээ үзүүлэгчидтэй операторын үйлчилгээний гэрээ байгуулсан. Ийм гэрээг “нүүрсний хулгай” гэх дуулиантай холбогдуулан 2023 оны эцсээр зохиогдсон УИХ-ын нээлттэй сонсголд хэлэлцсэнээр олны анхааралд өртөж байв. Эдгээр гэрээгээр уул уурхайн төслийн санхүүгийн болон бусад чухал нөхцөлийг зохицуулдаг тул тухайн төслийн санхүүгийн болон бусад үр нөлөөг ойлгох ач холбогдлын хувьд жишээ нь хөрөнгө оруулалтын гэрээтэй эн зэрэгцэх ач холбогдолтой юм. “Эрдэнэс Тавантолгой” зэрэг компаниуд уул уурхайн үйлчилгээ үзүүлэгчидтэй гэрээ байгуулдаг[26] гэдэг нь тодорхой боловч ОҮИТБС болон Гэрээний мэдээллийн санд операторын үйлчилгээний гэрээг нийтлээгүй байна. Тус компанийн вэб сайтад нэлээд хэрэгцээтэй мэдээллийг нийтэлдэг бөгөөд "Олборлолтын гэрээ" гэсэн хэсэгтэй боловч операторуудтай байгуулсан гэрээг нийтлээгүй. Холбогдох мэдээлэл дутмаг учраас ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг том хэмжээний бусад компаниуд ямар хэмжээнд оператор компаниудыг ашигладаг болохыг тодорхойлох боломжгүй байна.
- **Хамтран ажиллах гэрээ:** Ашигт малтмалын болон Газрын тосны тухай хуулийн дагуу энэ төрлийн гэрээг байгуулахыг шаарддаг бөгөөд байгаль орчин, уурхайн ашиглалт, дэд бүтцийн хөгжил, орон нутгийн хөдөлмөр эрхлэлт зэрэг асуудлаар орон нутгийн удирдлага болон уул уурхай, газрын тосны компаниуд хэрхэн хамтран ажиллахыг зохицуулдаг. Уг гэрээг орон нутгийн засаг захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хоорондоо

[25] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, Хавсралт 39, 40.
[26] Тухайлбал, 6 компани операторааp бүртгэгдсэн, Эрдэнэс Тавантолгой. “2023 оны үйл ажиллагааны тайлан, Хуудас 31” (Эрдэнэс Тавантолгой, 2024), www.ett.mn/mn/file-viewer/5747.

байгуулдаг бөгөөд Засгийн газраас баталсан гэрээний загварыг[27] ашиглах боломжтой. ОҮИТБС-ын тайланд нэлээд олон тооны хамтын ажиллагааны гэрээ (306) багтсан боловч энэ нь өнөөг хүртэл байгуулсан гэрээг бүгдийг агуулсан эсэх, эдгээр гэрээ хүчин төгөлдөр байгаа эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл байдаггүй.

- **Газар ашиглах гэрээ:** Ашигт малтмалын болон Газрын тухай хуульд заасны дагуу орон нутгийн засаг захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ гэрээг байгуулах шаардлагатай. Эдгээр гэрээг байгуулах нь хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахад зайлшгүй боловч олборлох үйл ажиллагааны талаарх чухал мэдээлэл энэ гэрээнд тэр бүр агуулагддаггүй. Гэрээний мэдээллийн сан, ОҮИТБС-ын тайланд энэ төрлийн олон тооны гэрээг нийтэлсэн боловч хүчин төгөлдөр үйлчилж буй бүх гэрээг хамруулсан эсэх талаар тайлбарлаагүй байна.
- **Ус ашиглах гэрээ:** Ашигт малтмалын болон Усны тухай хуульд тусгасан энэ төрлийн гэрээг орон нутгийн засаг захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулдаг. Гэрээний мэдээллийн сан, ОҮИТБС-ын тайланд энэ төрөлд хамаарах олон тооны гэрээг нийтэлсэн боловч хүчин төгөлдөр байгаа бүх гэрээг нийтэлсэн эсэх талаар тайлбар байхгүй.
- **Бүтээгдэхүүн хуваах гэрээ:** Газрын тосны тухай хуулиар шаарддаг энэ төрлийн гэрээ нь санхүүгийн нөхцөл, байгаль орчны төлөвлөгөө зэрэг асуудлыг зохицуулдаг бөгөөд Засгийн газар болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хоорондоо энэ гэрээг байгуулдаг. Газрын тосны компаниуд болон Засгийн газар хоорондын үндсэн хэлцэл, тохиролцоог зохицуулж, тухайн төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн асуудлыг хамардаг. Гэрээний мэдээллийн санд энэ төрлийн 11 гэрээг нийтэлсэн хэдий ч энэ нь өнөөг хүртэл байгуулсан бүх гэрээг хамруулсан эсэх нь мэдэгдэхгүй байна. Үүний нэг жишээ бол хамгийн том газрын тос олборлогч Дачин тамсаг компанитай байгуулсан гэрээг Мэдээллийн санд нийтлээгүй байна. ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд “28 талбайд 31 гүйцэтгэгч үйл ажиллагаа явуулж байна” [28] гэж дурдсан. Уг тайланд Гэрээний мэдээллийн санд нийтэлсэн гэрээний жагсаалтыг тусгасан бөгөөд үүнд зөвхөн 24 талбайтай холбогдох гэрээ[29], харин дараагийн хүснэгтэд олон нийтэд ил болсон 27 гэрээ[30]

---

[27]Монгол Улсын Засгийн газар. “Загвар гэрээ”, 2016. www.legalinfo.mn/mn/detail?lawId=207245&showType=1 .
[28] ОҮИТБС-ын Ажлын алба, “Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэлийн тайлан, Хуудас 79”.
[29] ОҮИТБС-ын Ажлын алба, Хүснэгт 59, Хуудас 89-90.
[30] ОҮИТБС-ын Ажлын алба, Хүснэгт 60, Хуудас 90-92.

багтжээ. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн байгууллага 2023 онд 15 компанид хамаарах 14 идэвхтэй, 4 идэвхгүй талбай[31] байгаа гэж мэдэгдсэн боловч бүтээгдэхүүн хуваах гэрээний тооны талаар нэгдсэн бөгөөд найдвартай мэдээлэл алга байна.

- **Тогтворжуулах гэрчилгээ:** Хэдийгээр гэрээ биш боловч тогтворжуулах гэрчилгээ нь хөрөнгө оруулагчдын төслийн төлбөрийн үндсэн нөхцөлийг зохицуулдаг. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу энэ асуудлыг зохицуулдаг бөгөөд тогтворжуулах гэрчилгээ авахад хөрөнгө оруулалтын доод хэмжээ 30 тэрбум төгрөг байх шалгуурыг хангасан байна. Тогтворжуулах гэрчилгээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр зэрэг тодорхой татварын төлөх хувь хэмжээг тогтмол хэмжээтэй байхаар заадаг. Тогтворжуулах нөхцөлийн үргэлжлэх хугацаа нь хөрөнгө оруулалтын хэмжээ, салбар, байршил зэргээс хамаарч 5-18 жилийн хооронд хэлбэлздэг. Хөрөнгө оруулагчид Засгийн газартай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ хүчингүй болно. Хөрөнгө оруулалтын тухай хуулиар (2013 онд батлагдсан) тогтворжуулах гэрчилгээ олгох болсноос өмнө Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн (1993 онд батлагдсан) дагуу Засгийн газар нь хөрөнгө оруулагчидтай тогтвортой байдлын гэрээ байгуулдаг байсан. ОҮИТБС-ын 2022 оны жилийн тайланд Гэрээний мэдээллийн санд тогтвортой байдлын 11 гэрээ нийтлэгдсэн гэж дурдсан байдаг ч зөвхөн нэгийг нь тус тайлангийн хавсралтад багтаасан.
- **Санхүүжилтийн зохицуулалтууд:** Засгийн газар нь зарим тохиолдолд төслийн тодорхой санхүүжилтийн зохицуулалтыг хөрөнгө оруулагчидтай хэлэлцдэг. Тухайлбал, Оюутолгой төслийн хувьд Засгийн газар нь өрийн бичиг худалдан авах гэрээ байгуулах гэх мэт зохицуулалтаар тус компаниас татварын урьдчилгаа төлбөр хэлбэрээр зээл авсан байдаг. Нийтлэг хууль тогтоомжид нийцүүлэн хоёр талын хооронд хэлэлцээ хийх замаар эдгээр гэрээг байгуулдаг бөгөөд тусгай хуулиар зохицуулаагүй тул ийм гэрээг ашиглаж буй цар хүрээг үнэлэхэд төвөгтэй. Мөн зарим тохиолдолд Засгийн газар нь төрийн өмчит болон бусад компаниудад банк болон бусад эх үүсвэрээс зээл авах баталгаа өгч болно.

---

[31] АМГТГ, “Гүйцэтгэгчдийн зардал”, 2024, www.view.officeapps.live.com/op/view.aspx?src=https%3A%2F%2Fmrpam.gov.mn%2Fpublic%2Fpages%2F49%2F%25D0%2593%25D1%258D%25D1%2580%25D1%258D%25D1%258D%25D0%25BB%25D1%258D%25D0%25B3%25D1%2587%25B3%25D1%2587%25BD0%220%25BD0%220B520% %25D0%25B7%25D0%25B0%25D1%2580%25D0%25B4%25D0%25B0%25D0%25BB%25202023.xlsx&wdOrigin=BROWSELINK.

ОҮИТБС-ын жилийн тайланд энэ төрлийн нэг ч гэрээг дурдаагүй бол Гэрээний мэдээллийн санд, жишээлбэл Оюутолгойн далд уурхайн төслийн санхүүжилтэд зориулсан гэх мэт наанадаж нэг гэрээ багтсан байна.

- **Оффтейк гэрээ:** Энэ төрлийн гэрээ нь ихэвчлэн санхүүжилтийн зохицуулалт эсхүл үйлчилгээний гэрээний нэг хэсэг байдаг бөгөөд төрийн өмчит аж ахуйн нэгжид илүү хамааралтай болно. Ихэнхдээ ийм хэлцлийг бартер солилцооны үндсэн дээр хийж, үйлчилгээ эсхүл санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид өгөх төлбөрийг бүтээгдэхүүний тодорхой хэсгээр гүйцэтгэдэг. Түүхий эдийн үнэ, чанарын талаарх урьдчилсан таамаглал нь ийм зохицуулалтын зардал, үр ашгийг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. ОҮИТБС-ын тайлан ба хавсралтад эдгээр гэрээний талаар мэдээлэл байхгүй.
- **Байгаль орчны зохицуулалт:** Монгол Улсын уул уурхайн компаниудын байгаль орчныг хамгаалах үүрэг нь хэд хэдэн хууль тогтоомж, бодлогын хүрээнд тодорхойлогдсон. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (2012 он) уул уурхайн компаниуд үйл ажиллагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (БОНБҮ) гүйцэтгэхийг шаарддаг. Уг үнэлгээ нь байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөх ёстой. Ашигт малтмалын тухай хуульд (2009 он) байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үүнд уурхайн хаалтын дараа байгаль орчинд учирч болзошгүй бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах, газрыг нөхөн сэргээх арга хэмжээ авахыг аж ахуйн нэгжүүдээс шаарддаг. Тогтвортой хөгжлийн бодлого (2012 он) нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг хамгийн бага хэмжээнд байлгахуйц хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхийг тусгасан. Түүнчлэн аж ахуйн нэгжүүд байгаль орчны нөхөн сэргээлтийн гэрээ байгуулдаг бөгөөд зарим гэрээг ОҮИТБС-ын жилийн тайланд тусгасан байна.

“2.2.a Хэрэгжүүлэгч улс орнууд нь тайлангийн хугацаанд ОҮИТБС-ын ил тайлагналд хамрагдсан компаниудын шинээр эзэмших болсон болон шилжүүлэн өгсөн болон авсан бүх гэрээ, лицензийн мэдээллийг ил тайлагнах ёстой...”[32]

[32] ОҮИТБС, “ОҮИТБС-ын 2023 стандарт”, Хуудас 17

ОҮИТБС-ын жилийн тайланд гэрээ байгуулсан огноо зэрэг тустай мэдээлэл бүхий, тайлант жилийн хугацаанд нийтэлсэн гэрээний жагсаалтыг тусгадаг.[33] Гэвч гэрээнд хамаарах хууль эрх зүйн ерөнхий заалтаас бусад мэдээлэл буюу тухайн гэрээлэгчийг сонгон шалгаруулах ерөнхий журмаас эхлээд гэрээлэгчийг сонгох техникийн болон санхүүгийн шалгуур, холбогдох зохицуулалтаас ялгаатай материаллаг зөрүүний талаарх нарийн мэдээллийг тусгаагүй. Эдгээр нь ОҮИТБС-ын Стандартын дагуу тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой нөхцөл боловч Монгол Улсад гэрээний хүрээнд ч мөн мөрдөж болно. Дээр 2.1 хэсэгт дурдсанчлан Монгол Улсын ОҮИТБС-ын тайлангийн хавсралтад чухал гэрээний жагсаалтыг оруулаагүй. ОҮИТБС-ын тайланд, Гэрээний мэдээллийн санд нийтэлсэн бүх гэрээг зөв тусгаагүйгээс гадна тайлангийн хугацаанд ямар гэрээ байгуулсан талаар тайлбарлаагүй байна.

2.2.а (үргэлжлэл) "Олон нийтэд нээлттэй буй мэдээлэлд ямар нэгэн орхигдсон хэсэг буй бол түүнийг тодорхой тайлбарласан байх шаардлагатай. Дээр заасан мэдээллийг иж бүрнээр ил тайлагнахад тулгарах эрх зүйн болон практик саад тотгорыг баримтжуулан, тайлбарлах ба үүнд Засгийн газрын зүгээс тухайн саад тотгорыг арилгах төлөвлөгөө, түүнийг биелүүлэх цаг хугацааг заах ёстой".[34]

ОҮИТБС-ын жилийн тайланд олборлох гэрээг олон нийтэд зориулж нийтлэхэд тулгарч буй бэрхшээлийн талаар тайлбар өгөөгүй. Жишээлбэл, дээр 2.1-д дурдсанчлан хэдийгээр зарим тогтвортой байдлын гэрээг Гэрээний мэдээллийн санд нийтэлсэн боловч ОҮИТБС-ын тайланд эдгээр тогтвортой байдлын гэрээ бүхий жагсаалтыг оруулаагүй. Түүнчлэн гэрээг олон нийтэд ил тод болгоход тулгарч буй хууль эрх зүйн болон практикт тулгарч буй бэрхшээлийн талаар эдгээр тайланд тусгаагүй.

Монгол Улсын хууль тогтоомжид дараах төрлийн гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгахыг шаарддаг.

- Хамтран ажиллах буюу орон нутгийн түвшний гэрээ, хэлэлцээр (Ашигт малтмалын тухай хуулийн 42.4-р зүйл)
- Төрийн өмчит компаниудын худалдан авах, худалдах гэрээ (Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийн 8.1, 8.4; Шилэн дансны тухай хуулийн 6.1.1)

[33] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, "Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан", Хавсралт 39
[34] ОҮИТБС, "ОҮИТБС-ын стандарт 2023, Хуудас 18."

Түүнчлэн эдгээр хуульд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (Ашигт малтмалын тухай хуулийн 57.4-р зүйл), байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (Ашигт малтмалын тухай хуулийн 57.4-р зүйл), байгаль орчныг хамгаалах тайлан (Ашигт малтмалын хуулийн 57.4-р зүйл) зэрэг байгаль орчны холбогдолтой баримт бичгийг ил тод болгохыг шаарддаг.

Олборлох салбарын хүрээнд орон нутгийн засаг захиргаа болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамтын ажиллагааны буюу орон нутгийн түвшний гэрээ байгуулдаг. Эдгээр гэрээг дээрх хууль тогтоомжийн дагуу байгуулж, Гэрээний мэдээллийн сан (iltodgeree.mn)-аар дамжуулан нийтэд нээлттэй болгож ирсэн. Тус мэдээллийн сан нь 2024 оны 2 дугаар сарын байдлаар 2009-2023 оны хооронд байгуулсан 790 гэрээг нийтэлсэн. 2022 оны ОҮИТБС-ын нэгтгэл тайланд дурдсанчлан орон нутгийн засаг захиргаатай 2009-2022 онд байгуулсан 695 гэрээ[35], 2023 онд байгуулсан орон нутгийн түвшний 95 гэрээг тусгасан байна.[36]

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (8.1, 8.4-р зүйл), Шилэн дансны тухай хууль (6.1.1-р зүйл)-д төрийн өмчит компаниудын худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ, худалдан авах, худалдах гэрээг нийтлэхийг шаарддаг. Шилэн дансны мэдээллийн сан нь[37] төрийн өмчит компаниудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтэлдэг боловч одоогоор худалдан авах болон борлуулалтын гэрээг тус мэдээллийн санд нийтлээгүй байна. Төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт зэрэг мэдээллийг жил бүрийн нэгдүгээр сарын 10-ны дотор Шилэн дансны мэдээллийн санд нийтлэх үүрэгтэй. Хуулийн хэрэгжилт ялангуяа төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүрээнд хангалтгүй бөгөөд ийм жигд бус хэрэгжилт нь хариуцлагын талаарх хуулийн хэллэг ойлгомжгүй, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар Засгийн газраас авах арга хэмжээ хангалтгүй, зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага сул зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж байна[38].

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн 57.4-т заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, байгаль

---

[35] ОҮИТБС-ын Ажлын алба. “Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан,” 2023. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/ccgk80kk82n69ur3/17-%D1%80%20%D1%82%D0%B%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf.

[36] Гэрээний мэдээллийн сан. “Гэрээний мэдээллийн сан”, www.iltodgeree.mn.

[37] Сангийн яам. "Шилэн дансны мэдээллийн сан." Шилэн Данс, www.shilendans.gov.mn .

[38] Намхайжанцангийн Дорждарь. “Монголын төрийн өмчит уул уурхайн аж ахуйн нэгжүүд: Шилэн дансны мэдээллийн гүнд,” 2022 оны 5 дугаар сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_mining_soe_deeper_look_into_glass_accounts_data.pdf .

орчныг хамгаалах тайлан зэргийг нийтэд мэдээлэх ёстой. Гэвч байгаль орчныг хамгаалах эдгээр баримт бичгийг нийтлэх хугацааг тодорхой заагаагүй, мөн нийтлэхгүй тохиолдолд авах арга хэмжээ тодорхой бус байна. Одоогоор зөвхөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг www.eic.mn вэбсайтаас авч болно. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах тайлан нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдэлд байдаг бөгөөд одоогоор нийтэд зориулж хэвлээгүй байна.[39]

Маргаантай байгаа нэг асуудал бол Засгийн газар болон аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан зарим гэрээг Захиргааны ерөнхий хуульд хамаарах захиргааны шийдвэр хэмээн үзэх эсэх юм.[40] Захиргааны ерөнхий хуулиар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг авах эрхийг олон нийтэд олгосон байдаг[41] бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан хамтын ажиллагааны гэрээг ил болгохыг зохицуулсан байдаг. Харин орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг захиргааны шийдвэр гэж үзвэл эцсийн гэрээг ил тод болгоод зогсохгүй хэлэлцээрийн болон гэрээг байгуулах явцад ч нэмэлт мэдээллийг олон нийтэд зориулж хэвлэн нийтлэх шаардлага үүснэ.

Хуулийн шаардлагатай холбоотойгоор Засгийн газар ОҮИТБС-ын тухай хуулийн төслийг бэлдэх үүргийг ОҮИТБС-ын ажлын төлөвлөгөөнд тусган хүлээж, улмаар УИХ-аар тус төслийг хэлэлцэн, батлах хүлээлт үүссэн байгаа.

2.2 (үргэлжлэл) "Олон талт оролцогчдын бүлэг нь ОҮИТБС-ын ил тайлагналд лицензолголтын тухай нэмэлт мэдээллийг оруулахыг дэмжинэ. Үүнд ... гэрээ эсхүл лицензийг шинэчлэх, түдгэлзүүлэх эсхүл цуцлах үйл явц, хэрэгжиж буй практик, үндэслэлийн тойм зэрэг багтаж болно..."[42]

ОҮИТБС-ын жилийн тайланд гэрээг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах журам, практик, үндэслэл бүхий мэдээлэл багтаагүй. Ийм журам, практикийн талаарх ихэнх мэдээллийг төслийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой зарим гэрээнээс авч болно. Тухайлбал, Оюутолгойн хөрөнгө

[39] Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээний газрын дарга Г.Энхмөнхтэй 2024 оны 2 дугаар сард хийсэн ярилцлага.
[40] Монгол Улсын Их Хурал. Захиргааны ерөнхий хууль (2015). www.legalinfo.mn/mn/detail/11259
[41] Монгол Улсын Их Хурал. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021). www.legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601
[42] ОҮИТБС, "ОҮИТБС-ын стандарт 2023, Хуудас 18."

оруулалтын гэрээ болон дагалдах хувь нийлүүлэгчдийн гэрээнд эдгээр гэрээг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийн талаар дэлгэрэнгүй тусгасан. Төслийн үйл ажиллагааны талаар гэрээ байгуулаагүй тохиолдолд эдгээр харилцааг Иргэний хууль гэх мэт одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2.4.a Хэрэгжүүлэгч улсууд нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгогдсон лиценз, хийсэн гэрээ эсхүл нэмэлт өөрчлөлт орсон гэрээ, лицензийг ил тод болгох шаардлагатай.

ОҮИТБС-ын 2022 оны жилийн тайланд тухайн онд байгуулсан гэрээний[43] мэдээллийг, 2021 оны тайланд тухайн жилд хамаарах гэрээний мэдээллийг тус тус тусгажээ.[44] Гэсэн хэдий ч гэрээний нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл байхгүй бөгөөд тайлант хугацаанд нэмэлт, өөрчлөлт хийгдсэн эсэх талаар тайланд дурдаагүй байна.

Дээрх 2.2.a хэсэгт заасны дагуу зарим гэрээг хуулийн дагуу нийтлэх шаардлагатай боловч гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг нийтэд мэдээлэх шаардлага хууль тогтоомжид байхгүй байна. Орон нутгийн удирдлагатай байгуулсан гэрээний ихэнх нь богино хугацааны гэрээ байдаг тул үндсэн гэрээний хугацаа дуусмагц талууд шинээр гэрээ байгуулдаг тул үндсэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулдаггүй.

2.4.a (үргэлжлэл) Хэрэгжүүлэгч орнууд нь ашигт малтмал, байгалийн хий, газрын тос олборлохтой холбоотой нөхцөлийг тодорхойлсон аливаа гэрээ, лиценз болон хайгуулын материаллаг ач холбогдолтой бүх гэрээг ил тайлагнахыг дэмжинэ.

Монгол Улсын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо эдгээр тусгай зөвшөөрлийн нөхцөлийг нарийвчлан тусгасан дагалдах гэрээ байгуулдаггүй. Харин тусгай зөвшөөрөлд хамаарах шаардлага, нөхцөлийг хууль тогтоомжид заасан байдаг. Засгийн газраас хөрөнгө оруулагчидтай хайгуулын тусгайлсан гэрээ байгуулах ёстой гэсэн шаардлага бүхий хууль тогтоомж байхгүй.

[43] ОҮИТБС-ын Ажлын алба, “Монголын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэлийн тайлан, Хавсралт 40”.
[44] ОҮИТБС-ын Ажлын алба, “Монголын ОҮИТБС-ын 2021 оны нэгтгэлийн тайлан, Хавсралт 40” 2022, www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2023/01/19/ktmvrh2dagte5km8/%D0%9E%D0298%D0%A2%D0%91%D0%A1-%D1%8B%D0%BD%2016%20%D0%B4%D1%83%D0%B3%D0%B0%D0%B0%D1%80%20%D0%BD%D1%8D%D0%B3%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf.

2.4.б. Олон талын оролцоот бүлэг нь гэрээг ил тайлагнах төлөвлөгөөг зөвшөөрч, нийтэлбэл зохих бөгөөд үүнд төлөвлөгөөг хэрэгжүүлэх тодорхой хугацаа болон иж бүрэн тайлагналд тулгарах саад тотгорыг арилгах үйл ажиллагааг тусгана. Энэхүү төлөвлөгөөг 2020 оноос эхлэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган нэгтгэнэ.

ОҮИТБС-ын жилийн төлөвлөгөөнд гэрээний ил тод байдлын талаарх мэдээллийг тусгадаг. Тухайлбал, 2023 оны ажлын төлөвлөгөөнд Монгол Улсад гэрээний ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн тодорхой зорилт болон түүний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг заасан байна.[45] Үүнд, ОҮИТБС-ын вэб хуудсыг сайжруулах, шинээр гэрээг байршуулах, гэрээг ил тод болгох чиглэлд ажилладаг холбогдох албан тушаалтны чадавхыг бэхжүүлэх зэрэг ажлыг төлөвлөгөөнд тусгасан. Түүнчлэн 2024 оны ажлын төлөвлөгөөнд өмнөх жилийн зарим арга хэмжээ, тухайлбал дээр дурдсан зарим ажлыг үргэлжлүүлэхээр болон бусад хэд хэдэн ажлыг төлөвлөсөн байна.[46] Эдгээр ажлын төлөвлөгөө бүхэлдээ ОҮИТБС-ын Стандартын шаардлагыг хангахыг зорьдог боловч тусгагдсан арга хэмжээ нь гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад тулгарч буй бэрхшээлийг арилгахад хангалттай эсэхийг дүгнэхэд хангалтгүй буюу нарийвчилсан биш байна.

2.4.в "Олон талт оролцогчдын бүлэг нь газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын хайгуул болон олборлолтын асуудлыг зохицуулсан гэрээ болон лицензийг ил тайлагнах чиглэлээр төр засгаас баримталж буй бодлогыг баримтжуулах шаардлагатай."

ОҮИТБС-ын жилийн тайланд олборлох гэрээ, түүнийг ил тод болгохтой холбоотой хууль тогтоомж, баримт бичгийг багтаасан боловч гэрээг нийтлэхтэй холбоотой асуудлыг эдгээр хууль тогтоомжид хэрхэн тусгасан тухай дэлгэрэнгүй тайлбар оруулаагүй байна. Эдгээр хууль тогтоомж нь гэрээний ил тод байдлын бодлогын талаарх мэдээллийг агуулж болох авч тухайн гэрээг байгуулах хууль эрх зүйн үндэслэл төдий мэдээлэл ч байх боломжтой.

Өмнөх хэсэгт дурдсаны дагуу байгаль орчныг хамгаалахтай холбоотой баримт бичгээс гадна орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, төрийн өмчит компанийн худалдан авалтын гэрээ

[45] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, "Монголын ОҮИТБС-ын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө" 2023, www.eitimongolia.mn/p/49?locale=en.
[46] Монголын ОҮИТБС-ын Ажлын алба, "Монголын ОҮИТБС-ын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө" 2024, www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/qg4jevohp8vr1cm4/Mongolia%20EITI%202024d%20.

зэрэг цөөн төрлийн гэрээг нээлттэй нийтлэх шаардлагыг хууль тогтоомжид тодорхой заадаг. Гэрээний мэдээллийн сан болон бусад хэрэгслээр дамжуулан олон тооны гэрээг ил тод болгосон ч хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэт тухайн төсөлтэй холбоотой гол гэрээ, хэлэлцээрийг нийтлэхийг шаарддаг хууль тогтоомж байхгүй нь Монгол Улсад гэрээг ил тод болгоход тулгарч буй гол бэрхшээл юм. Засгийн газраас ОУИТБС-ын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, гэрээний ил тод байдлын заалтыг тусгасан хуулийг батлуулна гэж зарласнаас хойш олон жил өнгөрсөн ч ажил хэрэг болоогүй байна. Гэрээний ил тод байдлыг хангах талаар Засгийн газрын үүрэг амлалтыг албаны хүмүүс, тэр дундаа Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд гэрээний цахим сангийн албан ёсны нээлтийн үеэр онцолж байсан. Хөрөнгө оруулалтын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, тэр байтугай орон нутгийн гэрээ зэрэг олборлох үйлдвэрлэлийн бүхий л гэрээ, хэлэлцээрийг вэб хуудас дээр нийтэлнэ гэж дэд сайд мэдэгдсэн.[47] Гэсэн хэдий ч гэрээг ил тод болгохын тулд одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд байгаа боломжийг ашиглах талаар дорвитой ахиц гараагүй байна. Тухайлбал, нийтэд нээлттэй мэдээлэх шаардлагатай бүх мэдээллийг тусгасан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг 2021 онд батлах үед олборлох гэрээг ил тод болгох шаардлагыг тус хуульд тусгах боломж байсан.

Засгийн газар гэрээний ил тод байдлыг хангах амлалтаа бусад олон сувгаар илэрхийлсэн. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар Нээлттэй засгийн түншлэлд оролцох замаар олборлох салбарын гэрээний ил тод байдлыг хангах хүсэл эрмэлзлээ удаа дараа илэрхийлсэн. Үүнд олборлох салбарын бүх төрлийн гэрээг ил тод болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгыг 2016-2018 оны болон 2021-2023 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрүүдэд[48] тус тус тусгасан юм.[49] Түүнчлэн 2024-2027 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрт[50] гэрээний ил тод байдлыг хангах амлалтаа дахин баталгаажуулсан.

Монгол Улсын авлигатай тэмцэх хүчин чармайлт нь гэрээний ил тод байдалд шууд бусаар нөлөөлөх боломжтой үйл ажиллагааг агуулж буй. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-

---

[47] Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам . “Олборлох гэрээ олон нийтэд нээлттэй.” Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, www.mmhi.gov.mn/2019/04/22/4456/.

[48] Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан”.

[49] Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засаг түншлэлийн 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан,” 2022 оны 7 дугаар сарын 21. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-review-2021-2023/.

[50] Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засаг түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2024 оны 1 дүгээр сарын 8. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december/.

2030”-т[51] гэрээний ил тод байдлыг хөндсөн тодорхой зүйл заалт байхгүй ч уг хөтөлбөр нь ерөнхийдөө ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн бөгөөд эерэг нөлөө үзүүлэх зорилтууд багтсан. Жишээлбэл, төрийн өмчийн уул уурхайн төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээлэл, түүнчлэн төрийн өмчит уул уурхайн компанийн худалдан авалтын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгохыг уг хөтөлбөрт тусгасан.

Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээ гэх мэт олборлолтын зарим чухал гэрээнд тухайн гэрээг нийтлэх талаар тодорхой шаардлагыг тусгасан байдаг. Гэсэн хэдий ч энэ заалт нь түгээмэл практик болж чадаагүйгээс гадна тухайн төсөлтэй холбоотой бусад олон гэрээнд ч хамаарахгүй, зөвхөн үндсэн гэрээтэй холбоотой юм.

2.4.в (үргэлжлэл) “Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил болгох талаар төрөөс баримтлах бодлогыг баримтжуулах шаардлагатай... Үүнд: ... Хууль эсхүл төрийн бодлого нь гэрээ болон лицензийг ил тод болгох асуудлыг хөндсөн эсэх, үүнд хууль тогтоомж болон бодлого нь гэрээ, лицензийг ил тайлагнахыг шаардсан эсхүл хориглосон эсэхийг тодорхой заах ёстой. Хэрэв үүнд хамаарах ямар нэгэн хууль тогтоомж байхгүй бол энэ талаар бодлогын баримт бичигт хэрхэн заасан, хэрхэн төлөвлөж буй болохыг тайлбарлах, мөн Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээний ил тод байдлын талаарх төрийн бодлогын бүрдэл хэсгийн талаар хэлэлцсэнийг баримтжуулсан байна. Гэрээ болон тусгай зөвшөөрлийн ил тод байдлын талаар төлөвлөж буй шинэчлэлийн тухай мөн баримтжуулан оруулсан байна”.

ОҮИТБС-ын жилийн тайланд гэрээний ил тод байдлын бодлогын талаар тайлбарлан баримтжуулаагүй байна. Уг баримт бичиг нь олборлох гэрээтэй холбоотой тодорхой хууль тогтоомж (гэрээний мэдээллийн сангаас авсан хүснэгт)-ийг дурдсан боловч эдгээр эшлэлийг тайлбарлаагүйгээс гадна ихэнх эшлэл нь гэрээг ил тод нийтлэх асуудалтай хамааралгүй байна. ОҮИТБС-ын жилийн ажлын төлөвлөгөөнд гэрээний ил тод байдлыг сайжруулах зорилт орсон боловч эдгээр зорилтыг дэмжих зорилгоор төрийн бодлогыг эргэн харж, өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагааг тусгаагүй байна. Ажлын төлөвлөгөөнд ОҮИТБС-ын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх бэлтгэл ажлын талаар дурдсан ч уг хуулийг хэзээ батлах нь тодорхой бус байна. Ийм нөхцөлд гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар эрх мэдлийнхээ

---

[51] Монгол Улсын Их Хурал. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”, 2023. www.legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851.

хүрээнд гэрээний ил тод байдлыг бэхжүүлэх талаар эрх зүйн хүрээнд юу хийж чадах вэ гэдэгт анхаарлаа хандуулах ёстой.

2.4.в (үргэлжлэл) "Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил болгох талаар төрөөс баримтлах бодлогыг баримтжуулах шаардлагатай... Үүнд: ... Ямар гэрээ, лиценз олон нийтэд нээлттэй буй талаарх тойм мэдээлэл орно. Хэрэгжүүлэгч улс орон нь хүчин төгөлдөр үйлчилж буй хайгуул, ашиглалтын бүх гэрээ, лицензийн жагсаалтыг нийтэлж, үүнд эдгээрийн аль нь олон нийтэд нээлттэй, аль нь хаалттай буй талаар мэдээлнэ. Нээлттэй нийтэлсэн гэрээ, лицензийн хувьд уг тойм мэдээлэл нь тухайн гэрээ, лицензийн байршсан холбоос, лавлах эх сурвалжийг заавал заасан байна. Хэрэв гэрээ эсхүл лицензийг ил тод болгоогүй бол үүнд тулгарч буй эрх зүйн болон практик саад тотгоруудыг баримтжуулан, тайлбарласан байна".

ОҮИТБС-ын жилийн тайланд газрын тосны салбар дахь бүтээгдэхүүн хуваах бүх гэрээний жагсаалт болон ихэвчлэн Гэрээний порталаас авсан уул уурхайн салбарын гэрээний урт жагсаалтыг оруулсан. Гэхдээ эдгээр жагсаалт иж бүрэн эсэх, жагсаалтад ороогүй гэрээ үлдсэн эсэх талаар тайлбарлаагүй. ОҮИТБС-ын 2021 оны жилийн тайланд нийтлэгдсэн гэрээг үзэх онлайн холбоосыг оруулсан боловч 2022 оны тайланд харин гэрээг онлайн үзэх холбоосгүйгээр жагсаасан байна. Ийм нөхцөлд ил тод нийтэлсэн гэрээний цар хүрээг олборлох салбарт мөрдөж буй холбогдох бүх гэрээний олонлогтой харьцуулан дүгнэх боломжгүй юм. Мэдээллийн портал нь гэрээг ил тод болгох чухал алхам боловч ОҮИТБС-ын шаардлагын дагуу нийтлэх ёстой бүх гэрээг хамруулж байгаа гэсэн баталгаа алга байна.

Судалгааны явцад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний мэдээллийг хүссэн боловч эдгээр байгууллагын аль нь ч тодорхой тоо мэдээлэл өгөөгүй болно.

Гэрээний мэдээллийн санг ННФ санхүүжүүлж, хариуцдаг тул төрийн бус байгууллагын хувьд гэрээг ил тод нийтлэх талаар Засгийн газар болон орон нутгийн удирдлагад шахалт үзүүлэх нөлөө дутмаг байна. Түүгээр ч зогсохгүй орон нутгийн түвшинд байгуулсан гэрээний бодит тоо болон тэдгээрийг Гэрээний мэдээллийн санд бүрэн нийтэлсэн эсэх талаарх мэдээлэл дутмаг байгаа тухай ННФ мэдэгдсэн. Гэрээний мэдээлэл цуглуулах, зохион байгуулах ажлыг хариуцахаар томилсон хүний нөөц дутмаг, эрх мэдэл нь хангалтгүй байгаатай холбож шалтгааныг тайлбарлаж байв. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам эсхүл ОҮИТБС-ын Ажлын

алба нь энэ мэдээллийн сангийн үйл ажиллагааг хариуцах ёстой гэдэг байр суурийг ННФ ярилцлагын үеэр илэрхийлсэн.

2.4.в (үргэлжлэл) "Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил болгох талаар төрөөс баримтлах бодлогыг баримтжуулах шаардлагатай... Үүнд: ... Ил тод болгох үйл ажиллагаа нь гэрээ, лицензийн ил тод байдалд хамаарах хууль эсхүл төрийн бодлогод тусгагдсан шаардлагуудтай зөрчилдсөн, өвөрмөц байдлаар хийгдсэн бол энэ талаарх тайлбарыг олон талт оролцогчдын бүлэг гаргах ёстой."

ОҮИТБС-ын жилийн тайланд гэрээг ил тод болгохтой холбоотой хууль тогтоомж, төрийн бодлогын талаарх мэдээллийг тусгаагүй тул хэрэгжилт, бодит байдалд дүн шинжилгээ хийх боломжгүй байна. Монгол Улсын хууль эрх зүйн өнөөгийн тогтолцооны дагуу хязгаарлагдмал хүрээний гэрээг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг шаарддаг. Хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн хуваах болон орд ашиглах зэрэг чухал ач холбогдолтой гэрээ, хэлэлцээр нь заавал ил тод нийтлэх шаардлагатай гэрээний төрөлд багтдаггүй тул зөвхөн гэрээний нөхцөлийн дагуу, эсхүл олон нийтийн шахалтаар гэрээг ил тод нийтэлдэг буюу тухайн тохиолдол тус бүрд үзэмжээр зохицуулдаг байна. Уул уурхайн төслүүдийг зохицуулдаг нөхцөлийн талаарх чухал мэдээлэл олон нийтэд хаалттай, заавал ил тод нийтлэх шаардлага болон цар хүрээ нь ийнхүү хязгаарлагдмал байгаа нь ил тод байдлыг хангахад саад болж байна. Гэрээг ил тод нээлттэй нийтлэх шаардлагыг хууль тогтоомжид тусгасан тохиолдолд ч хэрэгжилт нь харьцангуй жигд бус байна. Мэдээллийн санд нийтэлсэн гэрээний жагсаалт бүрэн бөгөөд үнэн зөв эсэхийг нягтлах арга хэрэгсэл байхгүй, уялдаа холбоо сул байгаа нь гэрээг ил тод нийтлэх ажлын үр нөлөөг бууруулж байна. Жишээлбэл, компаниуд орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан гэж мэдэгдсэн ч гэрээг мэдээллийн санд нийтлээгүй үед уг мэдэгдлийг бататгах боломж байхгүй байна. Монгол Улсын ОҮИТБС-ын нэгтгэл тайланд дурдсан гэрээнүүд Гэрээний мэдээллийн санд байхгүй эсхүл энэ мэдээллийн порталд нийтэлсэн гэрээг тайланд дурдаагүй тохиолдол гардаг. Хэдийгээр хуулиар шаарддаг боловч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан зэрэг баримт бичиг нь зөвхөн хязгаарлагдмал байдлаар нээлттэй нийтлэгдэж байна.

Дээр дурдсанчлан, Гэрээний мэдээллийн санг санхүүжүүлж, хариуцаж байгаа ННФ нь төрийн бус байгууллага тул Засгийн газар болон орон нутгийн удирдлагад гэрээг ил нийтлэх талаар шахалт үзүүлэх боломж дутмаг байгааг онцлох нь зүйтэй.

Шаардлага 4. Орлого төвлөрүүлэлт

4.2.а "Газрын тос, байгалийн хий эсхүл ашигт малтмалын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний төрд ногдох хэсгийг борлуулсны орлого эсхүл биет байдлаар хүлээн авсан бүтээгдэхүүн нь материаллаг дүнтэй бол Засгийн газар буюу төрийн өмчит аж ахуйн нэгж нь ... боломжтой тохиолдолд ... своп гэрээтэй холбоотой төлбөрийг (мөнгөн ба мөнгөн бус) ил тод болгох ёстой. Олон талт оролцогчдын бүлэг нь борлуулсан бүтээгдэхүүний өмчлөл болон борлуулах гэрээний нөхцөл (спот эсхүл хугацаат нөхцөлөөр)-ийн мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ".[52]

Монгол Улсын газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээнд мөнгөн бус хувь орлогыг тусгадаггүй учраас ОҮИТБС-ын стандартын энэхүү шаардлага нь Монгол Улсад хамаарахгүй.

4.2.б "Хэрэгжүүлэгч улс орнууд, үүнд төрийн өмчит аж ахуйн нэгж нь худалдан авагч компанийг сонгох, холбогдох борлуулалтын гэрээг зохицуулдаг эрх зүй, зохицуулалтын хүрээнээс материаллаг байдлаар гажсан аливаа тохиолдлыг ил тод болгохыг дэмжих" бөгөөд "хэрэгжүүлэгч улс орнууд нь худалдан авч буй компанитай холбоотой борлуулалтын гэрээг ил тод болгохыг дэмжинэ".[53]

Монгол Улс нөөц ашигласны төлбөр болон бусад татварыг хураах зорилгоор экспортын борлуулалтын гэрээг аж ахуйн нэгжүүдээс гаргуулан бүртгэж эхэлсэн. Гэсэн хэдий ч одоогоор борлуулалтын гэрээг нээлттэй нийтлэх, ил тод болгохыг шаарддаг ямар нэгэн хууль тогтоомж батлагдаагүй. ОҮИТБС-ын 2024 оны ажлын төлөвлөгөөнд төрийн өмчит компаниудын борлуулалтын гэрээг Гэрээний мэдээллийн санд байршуулах талаар тусгасан боловч өнөөдрийн байдлаар мэдээллийн санд ийм төрлийн гэрээг нийтлээгүй байна. Борлуулалтын гэрээний ихэнх нь нийтэд нээлттэй биш бөгөөд нүүрс экспортлогч "Эрдэнэс Тавантолгой" төрийн өмчит компани өөрийн цахим хуудаснаа ОҮИТБС-ын Стандартын 4.3.а хэсэгт хамаарах бартер солилцооны гэрээ болох зарим гэрээг нийтэлсэн байна.

4.2.г "...Компаниуд нь борлуулагч, гэрээ эсхүл борлуулалт тус бүрээр нарийвчилсан задаргаатай мэдээллийг ил тод болгохыг дэмжинэ. Худалдан авалт тус бүрийн талаар

[52] ОҮИТБС, "ОҮИТБС-ын стандарт 2023", Хуудас 28
[53] Өмнөхтэй ижил

ил тод болгож буй мэдээлэл нь хамаарах гэрээний нөхцөл (жишээ нь спот эсхүл хугацаат нөхцөл) болон ачилт хийсэн боомтын мэдээллийг агуулсан байж болно".[54]

Дээрх 4.2.b хэсэгт дурдсан борлуулалтын гэрээг нийтэд зориулж нийтлээгүй байна.

4.3 .a "Олон талт оролцогчдын бүлэг нь газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл, концесс олгож, төлбөрт нь бараа үйлчилгээг бүрэн болон хэсэгчлэн солилцоогоор ханган нийлүүлэх (зээл, тусламж өгөх, дэд бүтэц барих гэх мэт) үүрэг хүлээсэн нөхцөл бүхий гэрээ, хэлэлцээр эсхүл багц гэрээ хэлэлцээр байгаа эсэхийг заавал авч үзэх шаардлагатай." Түүнчлэн "тухайн гэрээ хэлэлцээ нь материаллаг тохиолдолд олон талт оролцогчдын бүлэг нь эдгээр гэрээг олон нийтэд цогц байдлаар тайлбарлах ёстой."

ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайланд дэд бүтцийн бартер солилцооны гэрээг тайлбарласан хэсэг орсон[55]. Ийм төрлийн 33 хэлэлцээрийг тайланд тусгаж, дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн хавсралтад оруулсан. Гэхдээ тайлагнаж буй талууд орон нутгийн иргэдэд өгсөн мөнгөн бус хандив, тоног төхөөрөмж худалдан авсан ажлыг гэрээнд оруулсан тул эдгээр 33 гэрээг бартер солилцооны гэрээнд тооцож болох эсэх нь тодорхойгүй байна. Энэ чиглэлийн тайланг сайжруулах, зөв, шаардлагатай мэдээллийг авахын тулд ОҮИТБС-ын загвар маягтыг өөрчлөх шаардлагатай байна.

"Эрдэнэс Тавантолгой" төрийн өмчит компанийн дэд бүтцийн ажилд Монгол Улс ихэвчлэн бартер солилцооны гэрээ байгуулсан. Анх нууцын зэрэглэлтэй байгуулсан эдгээр гэрээг "нүүрсний хулгай" гэх дуулианы үеэр тус компанийн вэб хуудас дээр нийтэлж, олон нийтэд нээлттэй хүргэсэн.[56] Эдгээр гэрээ нь энэ төрийн өмчит компанийн ирээдүйд олборлох нүүрсээр бартер солилцоо хийх замаар нүүрс тээвэрлэх төмөр зам барих, санхүүжүүлэхтэй холбоотой юм.

4.3.a (үргэлжлэл) "Хэрэгжүүлэгч улс орнууд бартер солилцоо буюу дэд бүтцийн гэрээ, түүний дотор баялгаар баталгаажсан зээлийн гэрээг ил тод нийтлэхийг дэмжинэ."

[54] ОҮИТБС, "ОҮИТБС-ын стандарт 2023", Хуудас 28.
[55] ОҮИТБС-ын Ажлын алба, "Монгол Улсын ОҮИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан, Хэсэг 6.3, Хуудас 136".
[56] "Нүүрс нийлүүлэх гэрээ", www.ett.mn, 2019 оны 11 дүгээр сарын 13, www.ett.mn/mn/news/single/5007.

Шууд баялгаар баталгаажсан зээлийн хэрэгслийг ашигласан эсэхийг мэдээлэл байхгүй ч өмнөх хэсэгт дурдсанчлан зарим төрийн өмчит компаниуд дэд бүтцийн бартер солилцооны гэрээг байгуулж, мөрдөж байна.

Шаардлага 6. Нийгэм, эдийн засгийн зардал

6.1.а "...Хэрэгжүүлэгч улс орнууд нь заавал зарцуулах шаардлагатай, материаллаг дүнтэй нийгмийн зардлын хэмжээ, хуваарилалтыг тайлбарласан, хуулиар шаарддаг гэрээ болон бусад баримт бичгийг ил тод нийтлэхийг дэмжинэ."

Хууль тогтоомжид, ялангуяа Ашигт малтмалын тухай хуульд заасан орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, эсхүл заримдаа орон нутгийн гэрээ гэж нэрлэгдэх гэрээнд нийгмийн зардлыг ихэнхдээ тусгадаг. Дээр дурдсанчлан эдгээр гэрээг нийтэд зориулж нээлттэй нийтлэхийг хуулиар шаарддаг. Эдгээр гэрээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй болгох мэдээллийн жагсаалтад тусгайлан заасан байдаг. ОУИТБС-ын тайлан, Гэрээний мэдээллийн сан нь аж ахуйн нэгжүүдийн орон нутагтай байгуулсан гэрээний тухай нэлээд мэдээлэл, мөн олон гэрээг нийтэлсэн. Гэвч гэрээний жагсаалт нь бүрэн эсэх, жагсаалтад орсон гэрээнүүд тайлагнах хугацаанд хүчин төгөлдөр эсэх нь тодорхойгүй байна.

6.1.б "Олборлох үйлдвэрийн компаниудын байгаль орчны чиглэлийн төр засагт төлсөн материаллаг дүнтэй төлбөрүүдийг хууль тогтоомж, журам, эсхүл гэрээгээр үүрэг болгосон тохиолдолд хэрэгжүүлэгч улс орнууд эдгээр шилжүүлгийг ил тод болгох ёстой. Байгаль орчинтой холбоотой төлбөрийг гэрээгээр үүрэг болгосон тохиолдолд хэрэгжүүлэгч улс орнууд нь эдгээр гэрээг ил тод нийтэлбэл зохино."

ОУИТБС-ын нэгтгэл тайлан, Гэрээний мэдээллийн сан нь байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой гэрээний жагсаалт болон гэрээг нийтэлсэн. ОУИТБС-ын тайлангийн хавсралтад ийм төрлийн 108 гэрээ (Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хүрээнд байгуулсан)-г нийтэлсэн ч энэхүү жагсаалт бүрэн эсэх нь баталгаагүй юм.

4. Дүгнэлт ба зөвлөмж

Монгол Улсын олборлох салбарт төрөл бүрийн гэрээ, хэлэлцээрийг байгуулж, мөрддөг бөгөөд тэдгээрийг ил тод болгох нь салбарын сайн засаглал, ил тод байдлыг дэмжих гол хүчин зүйл гэж хүлээн зөвшөөрөх явдал улам бүр нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд олборлох гэрээг ил тод болгох ажил эрчээ авч байгаа ч бүх гэрээг нийтэлсэн эсэх, тэр тундаа энэ салбарт байгуулсан нийт гэрээний тоо, ил тод нийтлэх шаардлагад хамаардаг гэрээний тооны талаар тодорхой ойлголт, мэдээлэл дутмаг байна. Одоогоор мэдэгдэж буй бүх гэрээний зөвхөн тодорхой хэсгийг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд мэдээлэх шаардлага тавигддаг. Монгол Улсын хууль тогтоомж болон бүх гэрээний жагсаалтыг хөтлөхийг шаарддаг ОҮИТБС-ын Стандарт хоёр хоорондоо зөрүүтэй байгаа нь гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад бэрхшээл учруулж байна. Хэдийгээр Монгол Улс гэрээний мэдээллийн тусгайлсан сан ажиллуулах зэрэг янз бүрийн санаачилга өрнүүлж байгаа ч хууль эрх зүйн тогтолцоо нь хязгаарлагдмал, хэрэгжилт нь жигд бус байгаа нь олборлох гэрээний талаарх олон нийтийн ойлголт, гэрээний хариуцлагатай байдалд саад тотгор болж байна. Засгийн газар гэрээний ил тод байдлыг сайжруулах амлалт өгч, мэдэгдэл хийдэг ч гэрээг олон нийтэд зориулж нийтлэх ажлыг шинэ шатанд гаргах, гэрээний ил тод байдлыг хангахтай холбоотой ОҮИТБС-ын Стандартын бүх шаардлагыг биелүүлэх ажлыг манлайлж чадахгүй байна. ОҮИТБС-ын тухай хуулийг батлах ажил удааширсан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд гэрээг нийтлэх шаардлагыг илүү тодорхой бөгөөд хэлбэрэлтгүй тусгах боломжийг алдсан, Гэрээний мэдээллийн санг тогтмол шинэчилж, бүх гэрээг цогц байдлаар бүрдүүлж чадахгүй байгаа, нийт гэрээг ил тод болгосон гэрээний жагсаалттай харьцуулах зорилгоор гэрээний иж бүрэн жагсаалтыг бэлтгэж өгөхийг ОҮИТБС-ын нэгтгэл тайланг бэлтгэж буй аудитораас шаардахгүй байгаа зэрэг нь үүнийг нотолж байна.

Эдгээр ажиглалтаас гадна олборлох салбарт гэрээний ил тод байдлыг бүрэн хангахад саад болж буй хэд хэдэн асуудал гарч ирж байгааг тодорхойлов. Үүнд:

- **Олборлох салбарт олон төрлийн, олон тооны гэрээ үйлчилж байгаа ч бүх гэрээг бүрэн хэмжээнд баримтжуулах, гэрээний бүрэн жагсаалтыг бүрдүүлэх механизм дутагдаж байна.** Хөрөнгө оруулалтын, хувь нийлүүлэгчдийн, орд ашиглах, хамтран ажиллах, газар болон ус ашиглах, бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тогтворжуулах гэрчилгээ зэрэг нь олборлох салбарт түлхүү үйлчилж байгаа гэрээний төрөл юм.

Харамсалтай нь эдгээр гэрээний төрөл бүрд нийт хэдэн гэрээ байгуулаад байгаа эсхүл одоо хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний тоо хэд болохыг тодорхойлж чадахгүй байна.

- **Гэрээг ил тод болгох шаардлага нь ОҮИТБС-ын Стандартын шаардлагыг биелүүлэх эсхүл олон нийтийн хүлээлтийг хангахад хангалтгүй, хязгаарлагдмал шинжтэй байна.** Монгол Улсын хууль тогтоомжид хамтын ажиллагааны гэрээ, байгаль орчны баримт бичиг, төрийн өмчит компаниудын худалдан авах, худалдах гэрээ зэрэг тодорхой гэрээг нээлттэй нийтлэхийг зохицуулсан. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах, орд ашиглах зэрэг чухал гэрээг ил тод нийтлэхийг хуулиар шаарддаггүй. Үүний зэрэгцээ “нүүрсний хулгай” зэрэг авлига албан тушаалын хэргээс харахад гэрээг цаг тухайд нь, бүрэн хэмжээнд нийтлэх нь олон нийтийн хяналтыг сайжруулж, авлигаас тодорхой хэмжээгээр урьдчилан сэргийлэхэд тустай байна.
- **ОҮИТБС-ын тайлан нь ОҮИТБС-ын Стандартын шаардлагыг хангаж чадахгүй байна**. ОҮИТБС-ын Стандарт нь урьдчилсан мэдээлэл, санхүүгийн болон санхүүгийн бус нөхцөл, захиргааны зохицуулалт зэрэг олон бүрэлдэхүүн хэсэг бүхий газрын тос, уул уурхайн бүх гэрээг ил тод болгохыг шаарддаг. Энэ тал дээр Монгол Улс ахиц гаргаж байгаа хэдий ч ОҮИТБС-ын гэрээний ил тод байдлын шаардлага болон гэрээг ил тод нийтлэх асуудлын хамрах хүрээний талаарх Монгол Улсын хууль тогтоомж, бодит ил тайлагналын хооронд ихээхэн зөрүү байна.
- **Засгийн газар гэрээний ил тод байдлын талаар алсыг харсан, идэвхтэй бодлого хэрэгжүүлэхгүй байна.** ОҮИТБС, Нээлттэй засгийн түншлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хэд хэдэн бодлого, санаачилга нь гэрээний ил тод байдлыг дэмждэг. ОҮИТБС-ын ажлын төлөвлөгөөнд гэрээг ил болгох шаардлагыг тусгасан ОҮИТБС-ын шинэ хуулийг батлах зэрэг гэрээний ил тод байдлын талаарх томоохон зорилтууд багтсан. Зарим төрийн өмчит аж ахуйн нэгж авлигыг буруулах зорилгын хүрээнд гэрээтэй холбоотой чухал мэдээллийг ил тод болгож, гэрээг вэб сайтдаа нийтэлдэг. Гэвч батлагдахаар хүлээгдэж буй ОҮИТБС-ын тухай хуулиас эхлээд ил тод байдалтай холбоотой бодлого ажил хэрэг болж, биеллээ олохгүй байна.
- **Гэрээний мэдээллийн сан нь гэрээг ил тод болгох чухал алхам боловч цар хүрээ нь хязгаарлагдмал байхаас гадна энэ ажлыг дэмжих хууль эрх зүй дутмаг байна.** Гэрээг ил болгох хамгийн чухал суваг болох тус мэдээллийн санд хууль тогтоомжийн дагуу нийтлэх шаардлагатай, орон нутгийн удирдлага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн

хооронд байгуулсан орон нутгийн түвшний гэрээг голчлон нийтэлж байна. ОҮИТБС-ын тайланд дурдсан болон мэдээллийн санд нийтэлсэн гэрээ зөрүүтэй байгаа нь Гэрээний портал дээрх мэдээлэл бүрэн эсэхэд эргэлзээ төрүүлнэ. Түүнчлэн гэрээг цуглуулах, мэдээллийн санд нийтлэх ажлыг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа бөгөөд энэ ажилд шаардлагатай хүчин чармайлтыг гаргаж байгаа ч аж ахуйн нэгж, засгийн газрын агентлагуудын эзэмшиж буй бүх гэрээг ил тод болгох шахалт үзүүлэх нөлөө, нөөц бололцоо хомс байна.

Дүгнэхэд Монгол Улс олборлох салбарын гэрээний ил тод байдлыг сайжруулах талаар олон ажил санаачилж байгаа ч бэрхшээл, сорилтууд байсаар байна. Холбогдох бүх гэрээг ил тод болгох эрх зүйн тогтолцоог шинэчлэх, хуулийг жигд бөгөөд тууштай хэрэгжүүлэх зэрэг бэрхшээлийг шийдвэрлэх нь гэрээний ил тод байдлыг сайжруулах, ОҮИТБС-ын стандартын шаардлагыг хангах, олон нийтийн ойлголт, хариуцлагыг төлөвшүүлэхэд нэн чухал юм. Эдгээрийг харгалзан Монгол Улсын олборлох салбарын гэрээний ил тод байдлыг сайжруулахын тулд дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

- **Гэрээний ил тод байдлыг манлайлах орон зайг нөхөх:** Засгийн газар гэрээний ил тод байдлыг хангах үүрэг амлалтаа дахин нотлох шаардлагатай. Түүнчлэн, ОҮИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг нь өмнөх амлалтууд яагаад биелээгүй эсхүл бүрэн хэмжээнд хэрэгжээгүй зэргийг дүгнэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээний төлөвлөгөөг богино хугацаанд багтааж боловсруулах нь зүйтэй.
- **Засгийн газрын эрх мэдлийг бүрэн дүүрэн ашиглах**: Засгийн газар нь олборлох салбарын гэрээг заавал нийтлэх шаардлагын цар хүрээг өргөжүүлэхийн тулд эрх зүйн тогтолцоог хянаж, шинэчлэх ёстой. Үүнд хөрөнгө оруулалтын, бүтээгдэхүүн хуваах болон орд ашиглах гэрээ зэрэг томоохон гэрээг олон нийтэд нээлттэй мэдээлэх, нийтлэх ажил багтаж байна. Гүйцэтгэх засаглал нь хууль батлах боломжгүй боловч гэрээний бүрэн жагсаалтыг бэлтгэн нийтлэх зэрэг хуулийн хүрээнд гүйцэтгэж болох олон ажил байна. Ялангуяа тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа олон төрийн өмчит компаниудын удирдлага нь гүйцэтгэх засаглалын бүрэн мэдэлд байдаг тул үүнийг ажил хэрэг болгох боломжтой. ОҮИТБС-ын тухай хуулийг УИХ-аар батлуулах тухай арав гаруй жил ярьж, энэ хуулиар шалтаглаж эрх зүйн боломжит шинэчлэлийг хойшлуулж байгааг хүлээн

зөвшөөрөх аргагүй юм. Улмаар гэрээний ил тод байдлыг сайжруулах амлалтыг ажил хэрэг болгох тал дээр Засгийн газар түүчээлж байгааг харуулах юм.

- **ОҮИТБС-ын тухай хуулийг УИХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах:** ОҮИТБС-ын тухай бие даасан хууль батлах нь ашигт малтмал ба газрын тосны хайгуул, ашиглалттай холбоотой гэрээг илүү өргөн хүрээнд ил тод нийтлэх хуулийн шаардлагыг тодорхой болгоход чухал нөлөөтэй байх болно. Засгийн газар нь салбарын ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхийн тулд энэ хуулийг батлахыг нэн тэргүүнд анхаарах ёстой. Гэсэн хэдий ч Засгийн газар нь ОҮИТБС-ын хуулийн төсөлтэй ижил түвшинд гэрээний ил тод байдлыг хангах хувилбаруудыг санал болгох буюу одоо мөрдөж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах боломжит хувилбаруудыг УИХ-д зориулж давхар боловсруулах ёстой.
- **Хэрэгжилтийг сайжруулах**: Хэрэгжүүлэгч агентлагууд Гэрээний мэдээллийн санд нийтэлсэн гэрээний бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангах хэрэгслийг боловсруулах ёстой. Жишээлбэл, нийтэлсэн гэрээг тайланд тусгасан гэрээтэй харьцуулан шалгах, Гэрээний порталын мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хянах, баталгаажуулах үйл явц, журмыг боловсруулах зэрэг ажил орно. ОҮИТБС-ын нэг чухал үүрэг нь гэрээг бүрэн хэмжээнд, өргөн хүрээнд, цаг тухайд нь нийтэлж буй ажлыг үнэлэх, дүгнэх ёстой юм.
- **Гэрээг сайн дураар ил тод нийтлэхийг дэмжих**: Зарим гэрээг ил тод байлгах, нийтлэхийг хуулиар шаарддаггүй ч Засгийн газар нь аж ахуйн нэгжийг хууль тогтоомжид зааснаас илүү өргөн хүрээний гэрээг сайн дураараа ил тод нийтлэхийг дэмждэг байх ёстой. Компаниудын сайн дурын санаачилгыг дэмжих, идэвхжүүлэх зорилгоор урамшуулах, сайшаах хөтөлбөрийг боловсруулж болно.
- **Иргэний нийгмийн оролцоог бэхжүүлэх**: Иргэний нийгмийн байгууллагууд ил тод байдлыг сурталчлан таниулах, оролцогч талуудад хариуцлага тооцоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газар иргэний нийгмийн бүлгүүдтэй идэвхтэй хамтарч, тэдний санал, бодлыг асуух, сайжруулах шаардлагатай чиглэлийг тодорхойлох зэргээр гэрээний ил тод байдлыг нэмэгдүүлэх санаачилга дээр хамтран ажиллах ёстой.
- **Чадавхыг бэхжүүлэхэд хөрөнгө оруулах**: Гэрээний ил тод байдлын шаардлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхийн тулд холбогдох оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх ажлыг өргөжүүлэх хэрэгтэй. Үүнд сургалтын

хөтөлбөр нь гэрээ тайлбарлах, ил тод нийтлэх, гэрээг хянах зэрэг сэдэв, агуулгатай байвал зохино.

- **Байгаль орчны баримт бичгийн хүртээмжийг сайжруулах:** Засгийн газар байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан зэрэг байгаль орчинтой холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд нээлттэй, ил тод болгох арга хэмжээ авах ёстой.
- **Тодорхой удирдамж боловсруулах:** ОҮИТБС-ын Олон талт оролцогчдын бүлэг нь гэрээг ил тод болгох шалгуур, тухайлбал ил тод нийтлэх шаардлагатай гэрээний төрөл, тайлагнах мэдээлэл, хэвлэн нийтлэх хэлбэр зэргийг тодорхойлсон тодорхой удирдамж, стандартыг боловсруулах ёстой. Энэ нь олборлох салбарыг гэрээг нийтлэх практикийг уялдаатай, жигд бөгөөд ил тод байлгахад тусална.

5. Хавсралт

Хавсралт А. Гэрээний төрөл

Монгол Улсын хэмжээнд Ашигт малтмал, Газрын тос, Цөмийн энерги, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдал, Хөрөнгө оруулалт, Шилэн дансны тухай хуулиудад газрын тос, ашигт малтмалын ашиглалттай холбоотой доор дурдсан 14 төрлийн гэрээ, байгаль орчныг хамгаалахтай холбоотой гурван үүргийг тусгажээ.

1. Хөрөнгө оруулалтын гэрээ
2. Орд ашиглах гэрээ
3. Нөхөн төлбөрийн гэрээ
4. Хамтын ажиллагааны гэрээ эсхүл орон нутгийн гэрээ (уул уурхай)
5. Газар ашиглалтын гэрээ
6. Ус ашиглалтын гэрээ
7. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ
8. Үүсмэл орд ашиглах гэрээ
9. Хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ
10. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг барьцааны гэрээ
11. Нууц хадгалах гэрээ
12. Бүтээгдэхүүн хуваах гэрээ
13. Хамтын ажиллагааны гэрээ (газрын тос)
14. Цацраг идэвхт бодисоос хамгаалах гэрээ (цацраг идэвхт ашигт малтмал)
15. Төрийн өмчит компаниудын худалдан авах, худалдах гэрээ
16. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
17. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
18. Байгаль орчныг хамгаалах хэрэгжилтийн тайлан

Засгийн газар нь 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 42.4-т заасан хамтын ажиллагааны гэрээ буюу орон нутгийн гэрээ (ашигт малтмал олборлох), 2021 онд батлагдсан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.1, 8.4 болон 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 6.1.1-д заасны дагуу төрийн өмчит компанийн худалдан авах, худалдах гэрээг ил тод нээлттэй нийтлэх үүрэгтэй. Түүнчлэн 2006 онд батлагдсан Ашигт

малтмалын хуулийн 57.4-т байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайланг ил тод болгохыг шаарддаг.

Хавсралт Б. Олборлох гэрээний жагсаалт

Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний тодорхой тоог Гэрээний мэдээллийн сан, бусад эх сурвалжаас авах боломжгүй байна.

#	**Гэрээний төрөл**	**Зохицуулах хууль**	**Таамаглаж буй тоо**	**Гэрээний мэдээллийн сан дээр нийтлэгдсэн**
1	Хөрөнгө оруулалтын гэрээ	Хөрөнгө оруулалтын тухай хууль	Тодорхойгүй	2
2	Орд ашиглах гэрээ	Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль	2*	0
3	Нөхөн төлбөрийн тухай гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	67
4	Хамтын ажиллагааны гэрээ эсхүл орон нутгийн гэрээ (уул уурхай)	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	306
5	Газар ашиглалтын гэрээ	Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль	Тодорхойгүй	125
6	Ус ашиглалтын гэрээ	Ашигт малтмалын тухай хууль, Усны тухай хууль	Тодорхойгүй	70
7	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	246
8	Үүсмэл орд ашиглах гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0
9	Хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0
10	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн барьцааны гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0
11	Нууц хадгалах гэрээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0
12	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Газрын тосны тухай хууль	~ 15	11 (хэсэгчилсэн)
13	Хамтын ажиллагааны гэрээ (газрын тос)	Газрын тосны тухай хууль	Тодорхойгүй	?
14	Цацраг идэвхт бодисоос хамгаалах гэрээ (цацраг идэвхт ашигт малтмал)	Цөмийн энергийн тухай хууль	Тодорхойгүй	
15	Төрийн өмчит компаниудын худалдан авах, худалдах гэрээ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль	Тодорхойгүй	
16	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	~5000
17	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0
18	Байгаль орчныг хамгаалах хэрэгжилтийн тайлан	Ашигт малтмалын тухай хууль	Тодорхойгүй	0

19	Хувь нийлүүлэгчдийн гэрээ	Компанийн тухай хууль	2*	0
20	Тогтворжуулах гэрчилгээ	Хөрөнгө оруулалтын тухай хууль	Тодорхойгүй	0

* Орано групп өөрийн вэбсайтад Хувь нийлүүлэгчдийн гэрээг Ашигт малтмал, газрын тосны газартай 2013 оны 10 дугаар сард байгуулсан, мөн Орд ашиглах гэрээг 2016 онд байгуулсан гэж нийтэлсэн байна.

Эх сурвалж

Бадрах Энержи www.badrakhenergy.com/en/home-en/ .

Намхайжанцангийн Дорждарь. “Монголын төрийн өмчит уул уурхайн компаниуд: Шилэн дансны мэдээллийн гүнд” 2022 оны 5 дугаар сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia_mining_soe_deeper_look_into_glass_accounts_data.pdf .

ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар. “ОҮИТБС-ын төрийн өмчит компанийн ил тод байдлын тухай товч мэдээлэл,” 2020 оны 11 дүгээр сар. www.eiti.org/sites/default/files/attachments/brief_soe_business_case.pdf .

———. “ОҮИТБС-ын Стандарт 2.4,” www.eiti.org/sites/default/files/2022-01/EN%20EITI%20GN_2.4.pdf

———. “ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх замаар авлигын эрсдэлийг шийдвэрлэх зааварчилгаа,” 2021 оны 12 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-02/Addressing%20corruption%20risks%20GN.pdf .

———. “ОҮИТБС-ын Стандарт 2.6 (Төрийн оролцоо ба ТӨК),” 2020 оны 10 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-02/en_eiti_gn_2.6.pdf .

———. “Монгол Улсын ОҮИТБС-ын Баталгаажуулалтын тайлан 2022” 2022 оны 10 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-10/EITI%20Validation%20of%20Mongolia%20%282022%29%20-%20Finalation%20Val%20%287-p_cap%202022%29%20%28EN%29.pdf .

———. “Баталгаажуулалтын талаарх Удирдах зөвлөлийн шийдвэр 2022,” 2022 оны 10 дугаар сарын 12. www.eiti.org/board-decision/2022-47 .

———. “Гэрээний ил тод байдлын бодлогын товч танилцуулга – Ази,” 2021 оны 2 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/attachments/eiti_contract_transparency_policy_brief_en_asia.pdf .

ОҮИТБС-ын Ажлын алба. “Монголын ОҮИТБС-ын 2006 оны нэгтгэл тайлан” 2007. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/alnb3bdv4ha7tcoc/Final_report_2006.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2007 оны нэгтгэл тайлан” 2008. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/ood0p77t7fz2li1v/Final_report_2007.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2008 оны нэгтгэл тайлан” 2009. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/qfl6ozov0o37cknm/Final_report_2008.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгтгэл тайлан” 2010. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/9n1k5ym3a73rig1f/Final_report_2009.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2010 оны нэгтгэл тайлан” 2011. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/dpgmsos3wkejjm2n/Final_report_2010.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгтгэл тайлан” 2012. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/qri3pzwotc2ndy2y/Final_report_2011.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны нэгтгэл тайлан” 2013. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/0zyek2xj02yr7anb/Final_report_2012.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2013 оны нэгтгэл тайлан” 2014. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/104103njpms3j88y/Final_report_2013.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны нэгтгэл тайлан” 2015. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/6tlew3933qijlsp5/Final_report_2014.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэл тайлан 2015” 2016. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/oyjqun4fbt0l1ppt/EITI_Report_2015_Mongolian.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэл тайлан” 2017. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/ygdhhpl8d5cgkp2m/Mongolia_OITI_Report_2016_Mongolian.pd .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны нэгтгэл тайлан” 2018. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/o46t85c8rbr9rvlo/EITI_report_2017_mn.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны нэгтгэл тайлан” 2019. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/c49dswx2qh5qqu86/Mongolia_2018_ОУИТБС-ын тайлан_MN-12.pdf30 .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны нэгтгэл тайлан” 2020. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/akv20vk30otsscy8/2020_FINAL%20EITI%2014%20N12pReport .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлан” 2021. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2022/01/05/hruavbf4lnnq8zo7/Mongolia%20EITI%202020%20Report0%20ind .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2021 оны нэгтгэл тайлан” 2022. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2023/01/19/ktmvrh2dagte5km8/%D0%9E%D2%AE%D0%98%D0%A2%D %91%D0%A1-%D1%8B%D0%BD%2016%20%D0%B4%D1%83%D0%B3%D0%B0%D0%B0%D1%80%20%D0%BD%D1%8D%D0%B3%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD. pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2022 оны нэгтгэл тайлан” 2023. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/ccgk80kk82n69ur3/17-%D1%80%20%D1%82%D0%B %B9%D0%BB%D0%B0%D0%BD.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС” www.eitimongolia.mn .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2012. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/95bbegys8pk3vv3k/ActionPlan2012en.pdf .

———. “Монголын ОУИТБС-ын 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2013. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/nxq13cmym8hhm6if/ActionPlan2013en.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2014. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/fe4x71hog1xhqv1n/EITIM_POA_2014en.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2015. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/d90478z2rigf3i2s/EITIMactioPlan2015en.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2016. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/31415gketn8cw8ds/Mongolia%20EITI%202016%20Ажлын төлөвлөгөө%20EIp .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2017. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/037wcl42mvronc1u/Mongolia%20EITI%20Ажил%20Plan%202017d%20Elish .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2018. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/ycijwzp81zc5du0h/Mongolia_OITI_2018_Ажлын_төлөвлөгөөний_хэрэгжилт_EN .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2019. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/qwg5hhkn7c6q0u21/Mongolia_OITI_2019_ажлын_төлөвлөгөө_EN.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2020. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/g7q3mm5qciyq31vs/Implementation%20status%20in%20Eng%20Mongolia%20in%20Eng%20Mongolia%20%20%202020%202020%2007%2010.pdf .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2021. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/03/ti6zj2pdawlvjntp/Mongolia%20EITI%202021%20Ажлын төлөвлөгөө%20% Englishp.

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2022. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2022/03/14/h98xwg3gc6hljtie/Mongolia%20EITI%202022%20Ажил%202%202p .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2023. www.eitimongolia.mn/p/49?locale=en .

———. “Монгол Улсын ОУИТБС-ын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2024. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2024/01/26/qg4jevohp8vr1cm4/Mongolia%20EITI%202024%20Ажил%f20төлөвлөгөө.p .

ОУИТБС ба Нээлттэй эзэмшил. “Ашиг хүртэгч эзэд эрх ба авлигаас урьдчилан сэргийлэх тухай товч мэдээлэл,” 2022 оны 12 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2022-12/OE%20Policy%20brief_Who%20benefits_0.pdf .

Монгол Улсын Засгийн газар. “Загвар гэрээ”, 2016. www.legalinfo.mn/mn/detail?lawId=207245&showType=1 .

GRI. "GRI дэлхийн тайлагнал." Дэлхийн тайлагнал, www.globalreporting.org/ .

Хуберт, Дон. “R 2.4-ийн дагуу ашиглалтын нөхцөлийг задруулах.” Resources for Development Consulting, 2022 оны 9 дугаар сар.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам. “ Байгаль орчны мэдээллийн сан www.eic.mn/

Сангийн яам. "Шилэн дансны мэдээллийн сан." Шилэн данс www.shilendans.gov.mn/ .

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам . “Олборлох гэрээ олон нийтэд нээлттэй.” www.mmhi.gov.mn/2019/04/22/4456/ .

———. “Эрдэс баялгийн салбарын статистик мэдээлэл 2023”. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 2023. www.mmhi.gov.mn/%d1%81%d0%b0%d0%bb%d0%b1%d0%b0%d1%80%d1%8b%d0% bd-%d1%81%d1%82%d0%b0%d1%82%d0%b8%d1%81%d1%82%d0%b8%d0%ba/ .

Монгол Улсын ОУИТБС-ын Ажлын алба. “Монголын ОУИТБС-ын 2021 оны нэгтгэл тайлан” 2022 оны 12 дугаар сар. www.eiti.org/sites/default/files/2023-01/ENG_EITI_Report_16_2022_Final.pdf

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээний газрын дарга Г.Энхмөнх, 2024 оны 2 дугаар сар.

Нээлттэй засгийн түншлэл. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2023-2027 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, 2024 оны 1 дүгээр сарын 8. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-2023-2027-december/ .

———. “Монгол Улсын Нээлтэй засгийн түншлэлийн 2016-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан”,

———. “Монгол Улсын Нээлтэй засгийн түншлэлийн 2021-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлан,” 2022 оны 7 дугаар сарын 21. www.opengovpartnership.org/documents/mongolia-action-plan-review-2021-2023/ .

Монгол дахь Орано групп. www.orano.group/en/orano-across-the-world/mongolia .

Оюу Толгой. “ Оюу Толгой”, www.ot.mn/agreements/ .

Монгол Улсын Их Хурал. “Авлигатай тэмцэх 2023-2030 үндэсний хөтөлбөр”, 2023. www.legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851 .

Роберт Питман. “Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд” 2019 оны 1 дүгээр сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolias-missing-oil-gas-and-mining-contracts.pdf .

———. “Монгол Улсад гэрээг ил болгох явдлыг эрчимжүүлэх нь” 2019 оны 2 дугаар сарын 26. www.resourcegovernance.org/articles/thawing-freeze-contract-disclosure-mongolia .

———. “Монгол Улсад гэрээг ил болгох явдлыг эрчимжүүлэх нь” 2019 оны 2 дугаар сарын 26. www.resourcegovernance.org/node/5327

———. Монгол Улсын газрын тос, уул уурхайн ил болоогүй гэрээнүүд” 2019 оны 1 дүгээр сар. www.resourcegovernance.org/sites/default/files/documents/mongolia-missing-oil-gas-and-mining-contracts-mn.pdf .

Роберт Питман, Намхайжанцангийн Дорждарь. “Монгол Улс уул уурхай, газрын тосны гэрээг нийтэд нээлттэй болгох амлалтаа дахин баталгаажууллаа” 2019 оны 5 дугаар сарын 3. www.resourcegovernance.org/articles/mongolia-reaffirms-commitment-publish-mining-petroleum-contracts .

Ил тод гэрээ. “Гэрээний мэдээллийн сан”, www.iltodgeree.mn .

Монгол Улсын Их Хурал. Ашигт малтмалын тухай хууль, www.legalinfo.mn/mn/detail/63 .

———. Газрын тосны тухай хууль, www.legalinfo.mn/mn/detail/10484 .

———. Захиргааны тухай хууль (2015). www.legalinfo.mn/mn/detail/11259 .

———. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021). www.legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601 .

———. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2022). www.d.parliament.mn/tusul/5979303a-58dd-4250-9370-7c214b8d88fd .

———. Цөмийн энергийн тухай хууль (нд). www.legalinfo.mn/mn/detail/97 .

———. Шилэн дансны тухай хууль (2014). www.legalinfo.mn/mn/detail?lawId=10497 .

Монгол Улсын ОУИТБС. “ОУИТБС-ын 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” 2012. www.resource4.sodonsolution.org/eitimongolia/File/2021/02/02/lvt66sw9zjsxbj4c/Plan_2012_mon.pdf .